



Оюу толгой

Орон нутгийн харилцаа

Шилжилт хөдөлгөөнийг удирдах төлөвлөгөө

Шилжилт хөдөлгөөнийг удирдах төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2017.03.31	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0007-М	Хувилбар: 2.0

АГУУЛГА

1. ТАНИЛЦУУЛГА	4
1.1 Төлөвлөгөөний ерөнхий тойм	4
1.2 Хэрэглээ	4
1.3 Хэрэгжиж эхлэх хугацаа	4
1.4 Бүрэн эрх ба удирдлага	4
2. ХУРААНГУЙ	5
3. АГУУЛГА, ХАМРАХ ХҮРЭЭ	6
3.1 ОТ –н бизнесийн нөхцөл байдал	6
3.2 Удирдлагын төлөвлөгөөний хамрах хүрээ	7
3.3 Бусад удирдлагын төлөвлөгөөнүүдтэй давхцах нь	7
4. ОТ –н ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА	8
4.1 Удирдлагын төлөвлөгөөний хэрэгжилтийг хариуцсан гол албан тушаалтан, түүний үүрэг хариуцлага	8
4.2 Удирдлагын төлөвлөгөөний засаглал	10
5. ХОЛБОГДОХ СТАНДАРТ, УЯЛДАА ХОЛБОО	11
5.1 Монгол улсын холбогдох хууль ба стандартууд	11
5.2 Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний шаардлага	13
5.3 ОТ –н Хөрөнгө оруулалтын гэрээ	13
5.4 Холбогдох олон улсын стандарт, журмууд	14
5.5 Рио тинто болон ОТ-н холбогдох стандартууд	14
5.6 ОТ- Өмнөговийн Хамтын Ажиллагааны Гэрээ (ХАГ)	15
6. ӨНӨӨГИЙН НИЙГМИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	17
6.1 Хүн амзүйн чиг хандлага	17
6.2 Хүн амзүйн судалгаа шинжилгээ	18
7. НЭГДҮГЭЭР ҮЕ ШАТНЫ ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДЛАГА (2011 – 2016)	20
7.1 Нэгдүгээр үе шатны шилжилт хөдөлгөөний эрсдэл	20
7.2 Нэгдүгээр үе шатанд хэрэгжүүлсэн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	20
7.3 Хүн амын бүтцийн тойм 2008 - 2015	22
7.4 Шилжилт хөдөлгөөний хяналт, осол зөрчил, эрсдлийг бууруулах арга хэмжээ 2011 - 2016	23
8. ХОЁРДУГААР ҮЕ ШАТНЫ ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДЛАГА (2017-2019)	24
8.1 АРГА БАРИЛ	24
8.2 Шилжилт хөдөлгөөний төрөл	25
8.3 ЗОРИЛТ	25
8.4 Шилжилт хөдөлгөөнийг бууруулах	26
8.5 ТААМАГЛАЛ	28
9. УДИРДЛАГЫН ХЯНАЛТ	28

Шилжилт хөдөлгөөнийг удирдах төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2017.03.31	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0007-М	Хувилбар: 2.0

10. ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУВААРЬ	29
10.1 Хэрэгжүүлэх гол хугацаа	29
10.1 Энэхүү удирдлагын төлөвлөгөөг хянах засвар оруулах	ERROR! BOOKMARK NOT DEFINED.
11. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ	ERROR! BOOKMARK NOT DEFINED.
11.1 Ерөнхий тойм	ERROR! BOOKMARK NOT DEFINED.
11.2 Хяналт шинжилгээний гол үйл явц	ERROR! BOOKMARK NOT DEFINED.
11.3 Оролцогч талууд	31
12. СУРГАЛТ	32
13. АУДИТ БА ТАЙЛАГНАЛ	32
13.1 Дотоод аудит	32
13.2 Хөндлөнгийн/гадаад аудит	32
13.3 Тайлагнал	32
14. БАРИМТ БИЧГИЙН МЭДЭЭЛЭЛ	33

ХҮСНЭГТ БОЛОН ЗУРАГ

Зураг 1: ОТ-н шилжилт хөдөлгөөний удирдлагын дотоод засаглалын диаграм	8
Зураг 2: Засаглалын харилцаа – Харилцааны хороо болон Хөгжлийг дэмжих сан	13
Хүснэгт 1: Удирдлагын төлөвлөгөөг хэрэгжүүлэх үндсэн үүрэг ба хариуцлага	6
Хүснэгт 2: Түншлэгч сумдын хүн амын статистик 2011 – 2015	14
Хүснэгт 3: Ханбогд хүн амзүйн чиг хандлага 2008 – 2015	14
Хүснэгт 4: Шилжилт хөдөлгөөнтэй холбоотой мэдээллийг ГГҮ-тэй харьцуулсан дүгнэлт	17
Хүснэгт 5: 2017 оны хэрэгжүүлэлтийн гол үе шат	23
Хүснэгт 6: ОТ-с тодорхойлсон гол оролцогч талууд	25

ХАВСРАЛТУУД

ХАВСРАЛТ 1: Шилжилт хөдөлгөөний сөрөг нөлөөллийг бууруулахад ОТ-с оруулсан томоохон хувь нэмрийн тойм

ХАВСРАЛТ 2: Шилжилт хөдөлгөөний нөлөөг удирдан зохицуулах төсөл/загвар, хяналт, үйл ажиллагаа, төсөл

ХАВСРАЛТ 3: Шилжилт хөдөлгөөний удирдлагын хяналтын ажил үүрэг, хариуцлага

ХАВСРАЛТ 4: Үр дүнг хянах гол үзүүлэлт

ХАВСРАЛТ 5: Үр дүнг хянах гол үзүүлэлт

Шилжилт хөдөлгөөнийг удирдах төлөвлөгөөХүчин төгөлдөр болох огноо:
2017.03.31Баримт бичгийн дугаар:
ОТ-10-PLN-0007-МХувилбар:
2.0**1. ТАНИЛЦУУЛГА****1.1. Төлөвлөгөөний ерөнхий тойм**

Энэхүү шилжилт хөдөлгөөнийг удирдах төлөвлөгөөний (удирдлагын төлөвлөгөө) зорилго нь түншлэгч сумдад уул уурхайтай холбоотойгоор эрчимжсэн шилжилт хөдөлгөөнийг удирдан зохицуулах аргыг тодорхойлох явдал юм. Удирдлагын төлөвлөгөөнд дараах асуудлууд тусгагдсан болно:

- ОТ-той холбоотой шилжилт хөдөлгөөний нөхцөл байдал, цар хүрээ, хэмжээ болон түүнийг удирдан зохицуулах арга замыг тодорхойлох;
- Шилжилт хөдөлгөөнийг удирдан зохицуулах үүрэг хариуцлагыг тодорхойлох;
- Шилжилт хөдөлгөөнийг удирдан зохицуулахтай холбоотой стандарт, гэрээ зэргийг тоймлон тодорхойлох;
- ОТ-н түншлэгч сумдын нийгэм, хүн амзүйн нөхцөл байдал, чиг хандлагыг тодорхойлж, дүн шинжилгээ хийх;
- 2011-2016 онд ОТ-н түншлэгч сумд руу чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөнтэй холбоотой Нэгдүгээр үе шатны шилжилт хөдөлгөөний эрсдэл, удирдлагын арга хэмжээ, үр дүнг тоймлон гаргах;
- 2017-2019 онд ОТ-н түншлэгч сумд руу чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөнийг удирдан зохицуулахтай холбоотой Хоёрдугаар үе шатны төлөвлөгөө, зорилт, таамаглал, хяналт, үйл ажиллагааг боловсруулах;
- Хоёрдугаар үе шатны ажлын явцад шилжилт хөдөлгөөний удирдлагын хяналт, тайлагнал, сургалтанд тавигдах шаардлагуудыг тоймлон тодорхойлох.

Дагалдах мэдээлэл, хэрэгжилтийн дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралтад, дүн шинжилгээг үндсэн хэсгийн 5, 6, 7-р хэсэгт танилцуулсан. Үндсэн мэдээлэл, удирдлагын төсөөлөл, зорилтуудын хураангуйг энэхүү танилцуулгын дараа оруулсан.

1.2. Хэрэглээ

Энэхүү удирдлагын төлөвлөгөөнд заасан шаардлагуудыг ОТ-н Гүний уурхайн төсөл, гүйцэтгэгчид зэрэг ОТ-н бүхий л үйл ажиллагаа, холбогдох үйл ажиллагаанд мөрдөнө.

Энэ удирдлагын төлөвлөгөөг 2015 оны 4 дүгээр сарын 1-нд гаргасан Рио тинтогийн Орон нутаг, нийгмийн гүйцэтгэлийн стандартад үндэслэн боловсруулсан. Энэхүү стандартад нэмэлт өөрчлөлт болон агуулгын өөрчлөлт орсон тохиолдолд тус удирдлагын төлөвлөгөөнд мөн өөрчлөлт орж болзошгүй юм.

Энэ удирдлагын төлөвлөгөө нь ЕСБХБ-ны Бодлого ба гүйцэтгэлийн шаардлагууд болон ОУСК-ийн Гүйцэтгэлийн стандарт 1, 4 ба 5-д нийцэж байгаа болно.

1.3. Хэрэгжиж эхлэх хугацаа

Энэхүү шинэчилсэн удирдлагын төлөвлөгөө нь 2017 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөс хэрэгжиж эхлэх бөгөөд 2013 оноос хойш хүчин төгөлдөр мөрдөгдөж ирсэн ОТ-н Нэгдүгээр үе шат шилжилт хөдөлгөөнийг удирдах төлөвлөгөөнийг орлоно.

1.4. Бүрэн эрх ба удирдлага

Энэхүү удирдлагын төлөвлөгөөг 2013 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр Оюу толгойн Гүйцэтгэх хороо зөвшөөрөн батлав.

ОТ-н Орон нутгийн харилцааны хэлтсийн Ерөнхий менежер нь энэхүү удирдлагын төлөвлөгөөний хариуцагч байна. Энэхүү удирдлагын төлөвлөгөөг өөрчлөхтэй холбоотой аливаа хүсэлтийг дээрх албан тушаалтанд гаргах ба тэрээр Өөрчлөлтийн удирдлагын журмын дагуу хянаж, батална.

Хуудас 4, Нийт 62

Шилжилт хөдөлгөөнийг удирдах төлөвлөгөөХүчин төгөлдөр болох огноо:
2017.03.31Баримт бичгийн дугаар:
ОТ-10-PLN-0007-МХувилбар:
2.0

Удирдлагын төлөвлөгөөг хоёр жил тутам эсхүл холбогдох төрийн байгууллага, Хамтын ажиллагааны гэрээний харилцааны хороо (ХАГХХ) болон санхүүжүүлэгч байгууллагуудын зүгээс анхаарал хандуулах тодорхой асуудлыг тусгасан албан ёсны хүсэлт гаргаснаар хянаж, нягтлан үзнэ.

2. ХУРААНГУЙ

ОТ-н уурхай, түүний туслах дэд бүтэц нь (нисэх буудал, сайжруулсан зам, усны кооногийн талбай, эрчим хүчний шугам зэрэг) Өмнөговь аймгийн Ханбогд суманд оршдог. Өмнөговь аймгийн хэмжээнд хүн амын өсөлтийн чиг хандлага нь уул уурхайн олон шинэ бүтээн байгуулалттай холбоотой боловч Ханбогд сумын хувьд хүн амын өсөлтийн чиг хандлага нь үндсэндээ ОТ-с хамааралтай байна. 2008 оноос хойш Ханбогд сумын хүн амын тоо жилд 7.6%-иар өссөн бөгөөд энэ нь ОТ-н Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээнд (БОННУ) жилд 13% байна гэж тооцоолсноос бага байгаа юм.

2010 онд улсын хэмжээнд хийгдсэн хүн амын тооллогоор Ханбогд сумын хүн ам 3,522 байснаас 1,455 (41%) нь сумын төвд амьдарч байсан; 2015 онд сумын нийт хүн амын тоо 5,344 болон нэмэгдэж, 4,280 (80%) нь сумын төвд амьдардаг гэж бүртгэгдсэн байна. Хүн амын өсөлтийн оргил үе нь ОТ-н Нэгдүгээр үе шат барилгын ажлын оргил үе болох 2011 онтой зэрэгцэн 12%-д хүрсэн бөгөөд 2015 онд буцаад 5.7% болсон. 10 жилийн хугацаанд жил бүр 7-8% -иар өсөх өсөлтийг ОТ болон засгийн газрын бүсийн хөгжлийн зорилтын хүрээнд зохицуулах боломжтой гэж үзсэн бөгөөд иргэний дэд бүтцийн барилга байгууламж, үйлчилгээ бий болж, сайжирч байна. Үүний адил Өмнөговийн төв Даланзадгад (4-5%-ийн өсөлт), Ханбогдын хөрш зэргэлдээ орших Манлай, Баян-Овоо сумдын (0-1%-ийн өсөлт) хүн амын өсөлтийг ОТ боломжтой хэмжээнд байна гэж үзсэн бөгөөд үүнийг Хамтын Ажиллагааны Гэрээний Харилцааны Хорооны хурлаар хэлэлцэж, баталгаажуулна.

Хүн ам зүйн хувьд зохицуулалттай (ажиллах хүч, ханган нийлүүлэлтийн хэлхээтэй холбоотойгоор шилжин ирэгсэд болон тэдний гэр бүлийн гишүүдээс голлон бүрдсэн) болон зохицуулалтгүй шилжилт хөдөлгөөн эрс нэмэгдсэн ч, ОТ-н зүгээс дэд бүтэц, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээг сайжруулах, орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмэр нь иргэдийн ая тухтай амьдрах нөхцлийг¹ хангах, сайжруулахад чухал ач холбогдолтой байлаа. Хүн амын өсөлт жилийн 3-13%-ийн хооронд хэлбэлзэж, оршин суух бүртгэлтэй хүмүүсийн тоо огцом өссөн ч (тухайлбал, 2016 оны 4 дүгээр сард 6387 хүн Ханбогдын оршин суугчаар бүртгүүлсэн), ОТ-н зүгээс авч хэрэгжүүлсэн шилжилт хөдөлгөөнийг хянах, удирдан зохицуулах төсөл/загвар, хяналт, үйл ажиллагаа, төслүүд бүхэлдээ үр дүнтэй байлаа.

ОТ-н хоёрдугаар үе шат буюу гүний уурхайн барилгын ажлыг ирэх 12-14 жилийн хугацаанд гүйцэтгэхээр төлөвлөж байгаагаас, ирэх дөрвөн жилийн хугацаанд ажиллах хүчний (ашиглалт, төслийн ажилтан) тоо хамгийн их/оргил үе буюу 7,000 хүрэх ба энэ нь 2012 онд гадарга дээрх барилгын ажлын ажиллах хүч хамгийн их буюу 17,000-д хүрснээс бага байна. ОТ энэ хугацаанд Өмнөговьд амьдарч, ажиллах ажилтнуудынхаа тоог аажмаар нэмэгдүүлж, одоогийн 22%-ийг 2025 онд 50%-д хүргэхээр төлөвлөж байна. Улаанбаатараас Даланзадгад руу онгоцоор ирж онгоцоор буцах (ОИОБ), Манлай, Баян-Овоо сумдаас машинаар ирж очих, Ханбогд сумын төвөөс өдөр бүр ажилдаа ирж очих загварыг тэнцвэржүүлэх замаар ажиллах хүч болон нийлүүлэлтийн сүлжээтэй холбоотой шилжилт хөдөлгөөнийг удирдан зохицуулна. Ажиллах хүчний суурьшлийн энэхүү холимог загвар нь ОТ, Засгийн газар, ажилтнуудын хэлэлцэж, тохиролцсоноор оршин суух газрын/суурьшлийн зорилгод нийцүүлэн хувилбарыг зохицуулах боломжийг ОТ-д олгох юм. Хувь хүний оршин суух газрын сонголтыг ажил амралтын хуваарь, тээвэрлэлтийн хувилбар, кэмпэд зохицуулалттайгаар байрлуулах зэргээр зохицуулна.

¹ Цахилгаан эрчим хүчний сүлжээ, ундны ус хангамжийн шугам сүлжээ, сумын төвд давхар хучилттай зам, сургуулийн дотуур байр, сум дундын шинэ эмнэлэг, шүдний эмнэлэг, хог хаягдлын байгууламж, нийтийн цэцэрлэгт хүрээлэн, тоглоомын талбай, цэнгэлдэх хүрээлэн, хувийн эзэмшлийн орон сууцны хангамжийг сайжруулах, жижиглэн худалдааг хөгжүүлэх, соёлын байгууламжуудыг сэргээн засварлах г.м (Хавсралт 1-г үзнэ үү)

Шилжилт хөдөлгөөнийг удирдах төлөвлөгөөХүчин төгөлдөр болох огноо:
2017.03.31Баримт бичгийн дугаар:
ОТ-10-PLN-0007-МХувилбар:
2.0

2025 оноос цааш ажиллах хүчний 50%-г Өмнөговьд суурьшуулахын тулд “хамгийн муугаар бодоход” Улаанбаатараас Өмнөговь руу жилд 320 орчим ажилтан, гэрээт гүйцэтгэгчдийг шилжүүлэн, Даланзадгад, Ханбогд болон бусад сумдад² хувь тэнцүүлэн хуваан суурьшуулах шаардлагатай болно. Хүн амын өсөлтийн чиг хандлагаас харахад эдгээр сумдад ОТ-той холбоотой оршин суугчдыг төвөггүй багтаах боломжтой. Жишээ нь, Ханбогдын хувьд өсөлтийн түвшин жилд 7-8% (жилд дунджаар 440-500 шинэ оршин суугч) байгаа ба ОТ-н 160 ажилтан Ханбогдод төвөггүй суурьших боломжтой бөгөөд энэ нь ОТ-н зүгээс Өмнөговьд жилд шилжүүлэн суурьшуулахаар төлөвлөж буй ажилтнуудын 50% байна.

Ханбогдод сүүлийн 10 жилд хүн амын өсөлтийн түвшин дунджаар 7-8% байгааг хүлээн зөвшөөрч болохуйц хэмжээ гэж үзэж байгаа бөгөөд ОТ болон засгийн газрын зүгээс нэгдүгээр үе шатны барилгын ажлын явцад туршиж, энэхүү төлөвлөгөөнд дурдсан төрөл бүрийн батлагдсан хяналт, арга хэмжээг авч хэрэгжүүлэх замаар дараагийн арван жилийн хугацаанд өсөлтийг хянаж, энэ түвшинг хэвээр хадгалахыг зорино. Дараагийн арван жилийн хугацаанд ОТ-н ажилтнуудыг суурьшуулах төлөвлөгөөний дагуу өсөлтийн өнөөгийн түвшинг нэмэгдүүлэлгүйгээр жил бүр ажилтнуудын гэр бүлийн гишүүд болон зохион байгуулалтгүйгээр шилжин ирэх 280-340 хүн шилжин суурьших боломжтой. 2015 оны 5.6%-ийн өсөлтийн түвшин нь 10 жилийн өсөлтийг тогтвортой байлгах хангалттай нөөц байгааг илэрхийлж байна.

Хүн амын өсөлтийн бодит түвшинг оршин суух хаягийн бүртгэлээс тусад нь хянах, оршин суух бүртгэлтэй хүмүүсийн тоо огцом өсөхөөс сэргийлэх нь Төлөвлөгөөний чухал бүрэлдэхүүн хэсгүүд юм. Үүний адилаар түншлэгч сумдын хэмжээнд зохицуулалттай болон зохицуулалтгүй шилжилт хөдөлгөөнийг багтаасан хүн амын бодит өсөлтийн хамтаар иргэдийн ая тухтай амьдрах нөхцлийг хангах, сайжруулах талаар засгийн газартай хамтарч ажиллах нь чухал.

3. АГУУЛГА, ХАМРАХ ХҮРЭЭ

3.1. ОТ –н бизнесийн нөхцөл байдал

Тус удирдлагын төлөвлөгөөнд хүн амзүйн загвар, **2011-2016 оны ОТ-н нэгдүгээр үе шат, барилгын ажил болон гадаргын эхний ажлуудын** явцад шилжилт хөдөлгөөний нөлөөллийг зохицуулахад авч хэрэгжүүлсэн арга хэмжээг авч үзсэн. Тус төлөвлөгөөний одоогийн агуулга нь ОТ-н гадарга дээр явагдаж буй үйл ажиллагаа, баяжмал боловсруулалт, тээвэрлэлт болон 2017-2019 онуудад явагдах **2-р үе шат ОТ-н Гүний уурхайн төсөл** юм.

ОТ-н гадарга дээрх байгууламжийн барилгын ажил, ил уурхайг ашиглалтанд оруулах ажил 2011-2014 онд хийгдсэн бөгөөд 2012 онд ажиллах хүчний тоо хамгийн их буюу 17,000-д хүрсэн. Одоогийн гадарга дээрх үйл ажиллагаа нь нийт 2,525 ОТ-н ажилтан (404 нь Өмнөговийх), 5,670 гэрээт гүйцэтгэгчийг (1405 нь Өмнөговийх) ажиллуулан, дунджаар 0.45 хувийн агуулгатай зэсээс жилд 700,000 тонн зэс үйлдвэрлэн гаргаж байна.

2016 оны 5-р сард ОТ-н хувь нийлүүлэгч талууд (Рио тинто, Туркойз хилл ресурс, Эрдэнэс Оюу Толгой) ОТГУ-н бүтээн байгуулалтын ажлыг “эхлүүлэх мэдэгдэл” өгсөн. Энэ нь 2013 онд газрын гадаргаас доош 1,300м-т 16 км хөндлөн малталт хийсэн гүний уурхайн ажлаас түр зогсоосноос хойш гурван жилийн дараа болсон үйл явдал юм. Одоогийн байдлаар төлөвлөөд байгаа гүний уурхайн ажил нь (Өмнөд Оюу, Хойд Хьюгогийн 1-р өргүүр) 2050 он хүртэл үйлдвэрлэлд зориулсан хүдрийн нөөцийг боловсруулан гаргана. Хойд Хьюгогийн 1-р өргүүрийн барилгын ажлыг ирэх 5-7 жилийн хугацаанд хийж гүйцэтгэх бөгөөд үүнд 200 км хөндлөн малталт, 2,200 хүдэр буулгах цэгийн ажил багтсан. Гүний уурхайн барилгын ажиллах хүч 3,000 орчим болох бөгөөд ихэнх (~95%) нь Монголчууд байна. Үйлдвэрлэл эхлэхэд гүний уурхай жилд дунджаар 1.66 хувийн зэсийн агуулгатай 40 сая тонн хүдэр, 1,800,000 тонн баяжмал үйлдвэрлэнэ (одоо 700,000 орчим тонн үйлдвэрлэж байгаатай харьцуулбал).

² ‘Хамгийн муугаар бодоход’ гэсэн нөхцөл нь Өмнөговийн оршин суугчдаас шинээр хүн ажилд авахгүй гэсэн хувилбарт нөхцөл юм.

Шилжилт хөдөлгөөнийг удирдах төлөвлөгөөХүчин төгөлдөр болох огноо:
2017.03.31Баримт бичгийн дугаар:
ОТ-10-PLN-0007-МХувилбар:
2.0

Ирэх 5-7 жилийн хугацаанд ОТ –н үйл ажиллагаа болон ОТГУ-д нийт 7,000 хүн ажиллах ба энэ нь 2012 онд ажиллах хүчний тоо хамгийн их буюу 17,000 ажилтан, гэрээт гүйцэтгэгчтэй байснаас бага байна. ОТ нь Өмнөговийн оршин суугчдыг ажилд авах талаар хүсэл эрмэлзэлтэй хэвээр байгаа бөгөөд ажилтан болон гэрээт гүйцэтгэгчийг ажиллуулах холимог аргыг ашиглан одоогийн байдлаар нийт ажиллах хүчний 22%-ийг эзэлж байгааг 50% болгохоор зорьж байна. Энэхүү холимог загвараар Улаанбаатараас Даланзадгад руу онгоцоор ирж онгоцоор буцах (ОИОБ), Манлай, Баян-Овоо сумдаас машинаар ирж очих, Ханбогд сумын төвөөс өдөр бүр ажилдаа ирж очих бөгөөд шилжилт хөдөлгөөний удирдлагын нэн чухал хэмжүүр болох ажиллах хүчний суурьшлийн хувилбарыг уян хатнаар хянах боломжтой болно.

2015 оны 2-р сард Ханбогдод оршин суух бүртгэлтэй хүмүүсийн тоо огцом өссөний дараа (7.4-р хэсгээс үзнэ үү) шинэ ажилтныг ажилд авах, тэр дундаа гэрээт гүйцэтгэгчийг ажилд авах зэрэг процессийг дотооддоо хянан шалгасан. Үүний үр дүнд Орон нутгийн харилцаа, Боловсон хүчин, зохион байгуулалт, Хангамжийн хэлтсийн хяналт зохицуулалтыг сайжруулж, ажилд авах процессийг чангатгасан. Ажилтнуудын суурьшлийн чиг хандлага, үйл ажиллагааны байнгын ажиллах хүчний байдал, хүний нөөц бүрдүүлэлт ба гэрээт гүйцэтгэгчдэд тавих хяналт харьцангуй сайжирсан. Ирэх 5-7 жилийн хугацаанд ОТГУ-д ажиллах нэмэлт 3,000 ажилтан нь голдуу ОИОБ ажил амралтын хуваарьтай, ажиллах хугацаандаа ОТ төслийн талбайд байрлах мэргэжлийн хүмүүс (гүний уурхайн) байна. Болзошгүй, зохицуулалтгүй шилжилт хөдөлгөөний хувьд бизнесийн нөхцөл байдал нь ерөнхийдөө 2014-2017 оны нөхцөл байдалтай төстэй байна.

3.2. Удирдлагын төлөвлөгөөний хамрах хүрээ

Энэхүү удирдлагын төлөвлөгөө нь ОТ-н шууд хэрэгжүүлж буй болон захиалан гүйцэтгүүлж буй бүхий л үйл ажиллагаанд хамаарна. Гүйцэтгэгчдийн ажлын хэрэгжилтийг Гүйцэтгэгчийн удирдлагын төлөвлөгөө (ОТ-07-PLN-0001-Е) – ний хүрээнд хянан удирддаг болно.

Удирдлагын энэхүү төлөвлөгөө нь ОТ-н түншлэгч сумдад³ хамаарах бөгөөд ОТ-с үүдэлтэй шилжилт хөдөлгөөнтэй холбоотой сөрөг болон эерэг нөлөөллүүдийг авч үзнэ. Түншлэгч сумд гэсэн нэр томъёо болон тодорхойлолт нь Шилжилт хөдөлгөөнийг удирдах өмнөх хувилбарууд болон МУ-ын БОНБНУ, санхүүжүүлэгчийн БОННУ зэрэг гуравдагч талын баримт бичгүүдэд “Шууд нөлөөллийн талбай”, “Шууд бус нөлөөллийн талбай” гэсэн нэр томъёо болон тодорхойлолтыг орлоно. Түншлэгч сумд гэсэн энэхүү нэр томъёоны хэрэглээг сайтар хэлэлцэж тохирсон бөгөөд ОТ болон түншлэгч сумдын хооронд байгуулсан Хамтын ажиллагааны гэрээгээр харилцан тохиролцсон протоколын хүрээнд амжилттай харилцаатай байгааг илэрхийлнэ. Энэхүү нэр томъёог удирдлагын төлөвлөгөөнд ашиглаж байгаа нь ОТ-н шилжилт хөдөлгөөнөөс үүссэн нөлөөллийг удирдан зохицуулахад түншлэгч сумдын орон нутгийн засаг захиргааны оролцоо улам бүр нэмэгдэж байгааг илэрхийлж байгаа болно.

Түүнчлэн энэхүү удирдлагын төлөвлөгөө нь шилжилт хөдөлгөөний мониторинг, нутгийн иргэдийн зөвлөлдөх уулзалтын үр дүн, тэднээс ирүүлсэн санал гомдол, осол зөрчлийг судлан шинжлэх явцад тодорхойлогдсон шаардлагад үндэслэн үе үе нэмэлт, өөрчлөлт хийгддэг уян хатан баримт бичиг юм. Төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд ОТ-н Хамтын ажиллагааны гэрээний Харилцааны хороогоор (ХАГХХ) дамжуулан түншлэгч сумдтай зөвшилцөх, хамтран ажиллах замаар болон ажиллах хүчний байршил, хүний нөөц бүрдүүлэлтийн стратеги, Өмнөговийн ханган нийлүүлэлтийн стратегийн амжилттай холбоотой асуудлаар ОТ болон МУ-ын Засгийн газрын гаргасан шийдвэр дээр үндэслэн аливаа өөрчлөлтийг оруулна.

3.3. Бусад удирдлагын төлөвлөгөөнүүдтэй давхцах нь

Энэхүү удирдлагын төлөвлөгөө нь Байгаль орчин ба нийгмийн менежментийн төлөвлөгөөний (ОТ-10-PLN-0003-Е) хүрээнд тодорхойлсны дагуу Оюу толгойн үйл ажиллагааны болон гүний уурхайн төсөлд зориулан боловсруулсан Үйл ажиллагааны Менежментийн Төлөвлөгөөний нэг бүрэлдэхүүн

³ ОТ Хамтын ажиллагааны гэрээнд (4.5-р хэсэг) тодорхойлсноор ОТ-н түншлэгч сумд нь Ханбогд, Манлай, Баян-Овоо болон Даланзадгад сумд болно.

Шилжилт хөдөлгөөнийг удирдах төлөвлөгөө

Хүчин төгөлдөр болох огноо:
2017.03.31

Баримт бичгийн дугаар:
ОТ-10-PLN-0007-М

Хувилбар:
2.0

хэсэг юм. Уг төлөвлөгөө нь удирдлагын бусад төлөвлөгөөтэй дараах байдлаар давхцан, уялдан холбогдоно:

- Орон нутгийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-PLN-0001-Е), ялангуяа хүн амын шилжилт хөдөлгөөний нөлөөллөөс үүссэн орон нутгийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны хөтөлбөртэй холбоотой асуудлууд.
- Хөдөлмөр эрхлэлтийн төлөвлөгөө (HR-10-PLN-0001-Е), ялангуяа ажил хайж шилжин ирэгсдээс үүсэх нөлөөллийг боломжит бага түвшинд байлгах болон ажиллах хүчний зан харилцааг зохицуулах, орон нутгийн оршин суугчдын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхтэй холбоотой асуудлууд.
- Гүйцэтгэгчдийн удирдлагын төлөвлөгөө (ОТ-07-PLN-0001-Е), ялангуяа гэрээт гүйцэтгэгчдийн зан харилцаа, үйлдэл, байрлал болон гэрээт ажилчдыг ажилд авахтай холбоотой асуудлууд.
- Талуудын оролцоог хангах төлөвлөгөө (ОТ-10-PLN-0008-Е), ялангуяа шилжилт хөдөлгөөний удирдлагын асуудлаар янз бүрийн оролцогч талуудыг татан оролцуулах арга, аргачлалтай холбоотой асуудлууд.
- Нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө (ОТ-10-PLN-0006-Е), ялангуяа эмзэг бүлгийн өрх болон нөлөөлөлд өртсөн малчин өрхүүдэд учрах сөрөг нөлөөллийг боломжит бага түвшинд байлгахтай холбоотой асуудлууд.
- Бэлчээрийн менежементийн стратеги, ялангуяа Өмнөговьд газар тариалан хөгжүүлэх, дэмжлэг үзүүлэхтэй холбоотой асуудлууд;
- Тээврийн удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-С3-PLN-0001-Е), ялангуяа ОТ-н лицензит талбайгаас гадуур явагдах ОТ-той холбоотой тээвэрлэлтийн үйл ажиллагааны асуудлууд.

4. ОТ –Н ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

4.1. Удирдлагын төлөвлөгөөний хэрэгжилтийг хариуцсан гол албан тушаалтан, түүний үүрэг хариуцлага

Удирдлагын төлөвлөгөөний хэрэгжилтийг хариуцсан гол албан тушаалтан, түүний үүрэг хариуцлагыг Хүснэгт 1-д тоймлон оруулав.

Хүснэгт 1: Удирдлагын төлөвлөгөөний хэрэгжилтийг хариуцсан гол албан тушаалтан, түүний үүрэг хариуцлага

Албан тушаал	Үүрэг хариуцлага
Орон нутгийн харилцаа хариуцсан Ерөнхий менежер	<ul style="list-style-type: none"> • Шилжилт хөдөлгөөнийг удирдах төлөвлөгөөнийг боловсруулах, хэрэгжүүлэх, хянах, үнэлэх, шалгах ерөнхий хариуцлагыг хүлээнэ. • Гомдол хүсэлт зэрэг шилжилт хөдөлгөөнтэй холбоотой асуудлын эрсдлийг үнэлэх, ангилах, Өмнөговийн удирдах хороо болон Хамтын ажиллагааны гэрээний Харилцааны хороонд мэдэгдэх • Шилжилт хөдөлгөөнийг бууруулах асуудлаар хариу тайлбар, идэвхтэй ажиллах төлөвлөгөө боловсруулан, ӨГҮХ-нд танилцуулах. • ӨГҮХ, ХАГХХ, Гүйцэтгэх хороо болон ОТ-н ТУЗ-д бүс нутгийн нийгэм- эдийн засгийн хөгжил, шилжилт хөдөлгөөний удирдлагын талаар тайлагнах. • Түншлэгч сумдын нийгэм-эдийн засгийн хөгжил, шилжилт хөдөлгөөнтэй холбоотой асуудлаар үндэсний, Өмнөговийн болон түншлэгч сумдын

Шилжилт хөдөлгөөнийг удирдах төлөвлөгөө

Хүчин төгөлдөр болох огноо:
2017.03.31

Баримт бичгийн дугаар:
ОТ-10-PLN-0007-М

Хувилбар:
2.0

	<p>удирдлагатай/засаг захиргаатай бүтээлч, нээлттэй харилцаа тогтоох.</p> <ul style="list-style-type: none"> Хүн ам зүйн байдалд нөлөөлж болзошгүй ОТ-той холбоогүйгээр үүсэн бий болж буй болон нуугдмал байгаа нөлөөллийн талаар ойлголтой болох зорилгоор Өмнөговь аймгийн төрийн/захиргааны албан тушаалтнууд, олборлох үйл ажиллагаа эрхлэгчид болон хөрөнгө оруулагчидтай албан болон албан бус төрөл бүрийн хэлбэрээр хамтарч ажиллах.
<p>Орон нутгийн харилцааны хэлтсийн Эрх зүйн, удирдлага зохицуулалтын менежер</p>	<ul style="list-style-type: none"> Шилжилт хөдөлгөөнтэй холбоотой үзүүлэлтүүдийг хянаж, шилжилт хөдөлгөөн зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд удирдан зохицуулах арга хэмжээний талаар Орон нутгийн хэлтсийн Ерөнхий менежерт санал зөвлөмж өгнө. Шилжилт хөдөлгөөнтэй холбоотой асуудлыг Нийгмийн эрсдэлийн үнэлгээнд тусгаж, шилжилт хөдөлгөөнтэй холбоотой гомдол, осол зөрчил, алдаа дутагдлыг Орон нутгийн харилцааны хэлтсийн Ерөнхий менежер, ӨМУХ-нд танилцуулж, хариу арга хэмжээ авах. Шилжилт хөдөлгөөний удирдлагын эрхзүйн хэрэгжилтийн тайланг зохицуулж, шилжилт хөдөлгөөнтэй холбоотой асуудал, арга хэмжээг санхүүжүүлэгч, аудитор, ХАГХХ зэрэг холбогдох оролцогч талуудад мэдээлэх.
<p>Орон нутгийн харилцааны хэлтсийн түншлэл, олон нийтэд дэмжлэг үзүүлэх асуудлыг хариуцсан менежер</p>	<ul style="list-style-type: none"> Ханбогд суманд удирдлагын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, ОТ төслийн талбай дахь холбогдох хэлтэс, албан тушаалтнуудын дунд зохицуулалт хийх. ОТ-н төслийн талбай дахь орон нутгийн хэлтсийн багийн шилжилт хөдөлгөөний удирдлагатай холбоотой үйл ажиллагааны хэрэгжилтийг удирдан зохицуулах.
<p>Даланзадгад дахь Төлөөлөгчийн газрын менежер</p>	<ul style="list-style-type: none"> ОТ-н шилжилт хөдөлгөөнийг удирдах төлөвлөгөөний ерөнхий загвар, хэрэгжилт, хяналт, үнэлгээ, удирдлагын чиглэлээр Орон нутгийн харилцаа хариуцсан Ерөнхий менежерт дэмжлэг үзүүлэн ажиллах Бүс нутгийн нийгэм – эдийн засгийн хөгжил, шилжилт хөдөлгөөнтэй холбоотой асуудлаар Өмнөговийн засаг захиргаа, ХАГХХ-той бүтээлч, нээлттэй харилцаа тогтоох.
<p>Өмнөговийн удирдах хорооны бүрэлдэхүүн (ӨГУХ):</p> <ul style="list-style-type: none"> Үйл ажиллагаа хариуцсан Ерөнхий менежер ОТ Гүний уурхайн төслийн Ерөнхий менежер Хүний нөөц хариуцсан Ерөнхий 	<ul style="list-style-type: none"> Шилжилт хөдөлгөөнийг удирдах төлөвлөгөөнийг хэрэгжүүлэх талаар стратегийн удирдамж өгөх, ОТ-н эрсдэлийн бүртгэл дэх Өмнөговийн эрсдлийн бүртгэлийг хянах, шилжилт хөдөлгөөний үзүүлэлтүүдийг хянах, шилжилт хөдөлгөөнтэй холбоотой асуудлаар хэлтсийн болон нийт үйл ажиллагааны хариуцлагын хязгаарыг тогтоох, Орон нутгийн харилцаа хариуцсан Ерөнхий

Шилжилт хөдөлгөөнийг удирдах төлөвлөгөө

Хүчин төгөлдөр болох огноо: 2017.03.31	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0007-М	Хувилбар: 2.0
---	--	------------------

<p>менежер</p> <ul style="list-style-type: none"> - Орон нутгийн харилцаа хариуцсан Ерөнхий менежер - Хангамжийн хэлтсийн менежер <p>Шилжилт хөдөлгөөний удирдлага нь байнгын хэлэлцэх асуудал болно.</p> <p>Хорооны бүтэц, үүрэг хариуцлага нь гадарга дээрх үйл ажиллагаа болон ОТГУ-тай холбоотой хамтран болон бие даан хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлно.</p>	<p>менежерийн бизнест нэн чухал, шилжилт хөдөлгөөнтэй холбоотой асуудлаар гаргасан саналыг Удирдах хороонд оруулах.</p> <ul style="list-style-type: none"> • ОТ-н түншлэгч сумдын хөгжилд дэмжлэг үзүүлэх, шилжилт хөдөлгөөнтэй холбоотой сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн ОТ-н орон нутгийн оролцоо болон бусад бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр ОТ-н үйл ажиллагааны хэлтсүүд (тухайлбал, Хангамж, Хүний нөөц), холбогдох гадны оролцогч талуудтай холбоо тогтоох, хамтарч ажиллах. • Удирдах хороонд улирлын тайлан гаргаж өгөх.
<p>Гүйцэтгэх захирал болон Удирдах хорооны баг</p>	<ul style="list-style-type: none"> • Орон нутгийн харилцаа хариуцсан Ерөнхий менежерийг санал болгож, ӨГУХ-р баталсан шилжилт хөдөлгөөнтэй холбоотой асуудлын стратеги, шилжилт хөдөлгөөнтэй холбоотой гол асуудлаар бизнесийн үйл ажиллагааны шийдвэр гаргах.

4.2. Удирдлагын төлөвлөгөөний засаглал

Тус удирдлагын төлөвлөгөө нь доорх гурван чиглэлийн ажлыг хамрах бөгөөд үүнд:

- 1) Орон нутгийн хөдөлмөр эрхлэлт, ЭМААБООН, орон нутгийн худалдан авалт/хангамжийн талаарх ОТ-н стратеги;
- 2) Түншлэгч сумд, Өмнөговийн засаг захиргаатай хамтран хийгдэх шилжилт хөдөлгөөний мониторинг;
- 3) Түншлэгч сумдын хүн амын өсөлттэй уялдуулсан тогтвортой хөгжлийн хөтөлбөр, дэд бүтцийн төслүүд

Гурван чиглэлийн хүрээнд дотоодын удирдлагын үүрэг хариуцлагын хуваарилалтыг (RACI загвараар) Зураг 1-д харуулав.

Зураг 1: Шилжилт хөдөлгөөний удирдлагын ОТ-н дотоод засаглалын диаграм

	Орон нутгийн ажил эрхлэлт, ЭМААБООН, орон нутгийн ханган нийлүүлэлтийн талаарх ОТ-н стратеги	Шилжилт хөдөлгөөний хамтарсан хяналтын үйл ажиллагаа	ХДС-Тогтвортой хөгжлийн хөтөлбөр, дэд бүтцийн төсөл
Түншлэгч сумдын удирдлага, аймаг	Зөвлөлдөх	Зөвлөлдөх	Зөвлөлдөх
Харилцааны хороо	Мэдээлэл авах	Зөвлөлдөх	Эрэмбэлэх, санал зөвлөмж өгөх
ХДС-ийн ТУЗ	Мэдээлэл авах	Мэдээлэл авах	Хэлэлцэж, батлах
Орон нутгийг дэмжих баг	Зөвлөлдөх, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх	Мэдээлэл авах	Мэдээлэл авах
Төлөөлөгчийн газрын менежер	ШХУТ-ний хэрэгжилтийг хариуцах	Хариуцах	Хариуцах
Хангамжийн хэлтсийн Ерөнхий менежер	Орон нутгийн хангамж/худалдан авалтыг хариуцах	Мэдээлэл авах	Мэдээлэл авах

Хуудас 10, Нийт 62

Шилжилт хөдөлгөөнийг удирдах төлөвлөгөө

Хүчин төгөлдөр болох огноо:
2017.03.31

Баримт бичгийн дугаар:
ОТ-10-PLN-0007-М

Хувилбар:
2.0

Хүний нөөцийн Ерөнхий менежер	Орон нутгийн ажил эрхлэлтийг хариуцах	Мэдээлэл авах	Мэдээлэл авах
Орон нутгийн харилцаа хариуцсан Ерөнхий менежер	ШХУТ-ний хэрэгжилтийг хариуцах	Зөвлөлдөх	Мэдээлэл авах
Өмнөговийн Удирдах хороо	Зөвлөлдөх, санал зөвлөмж өгөх	Зөвлөлдөх	Мэдээлэл авах
Гүйцэтгэх захирлын баг	Хэлэлцэх, батлах	Мэдээлэл авах	Зөвлөлдөх

Түншлэлийн хороо

2017 оны 3-р сард ОТ болон Өмнөговийн удирдлага хамтран Өмнөговийн түншлэлийн хороо (ӨГТХ) гэсэн хамтарсан хяналтын бүтцийг бий болгохоор тохиролцсон. 2017 оны эцсээр ӨГТХ нь ӨМУХ-г бүрэн орлоно. 2017 оны эцсээр талууд удирдлагын талаар тохиролцоонд хүрмэгц ӨГТХ нь ӨГУХ-г бүрэн орлоно.

ӨМТХ-ны анхны хурал 3-р сарын 26-27-ны өдрүүдэд Даланзадгадад болж, Өмнөговь аймаг, Ханбогд, Манлай, Баян-Овоо, Даланзадгад сумдын улс төрийн удирдах хүмүүс, албаны хүмүүс, Оюу толгой, Эрдэнэс оюу толгой компанийн Гүйцэтгэх захирал болон дээд удирдлагын хүмүүс оролцсон.

Хурлаар талууд Түншлэгч сумдын одоогийн нөхцөл байдал, саад бэрхшээл, тулгараад байгаа асуудлыг хэлэлцэж, хоёр сар тутам хуралдаж, дараах чиглэлээр ажиллах ажлын хэсэг байгуулахаар тохиролцсон:

- тогтвортой хөгжлийн стратегийн нийцэл;
- орон нутгийн ханган нийлүүлэлт;
- орон нутгийн хөдөлмөр эрхлэлт;
- Хамтын ажиллагааны гэрээний хэрэгжилт, Говийн оюу хөгжлийг дэмжих сангийн төсөл, хөтөлбөрүүд;
- Шилжилт хөдөлгөөн, засаглал/удирдлага зэрэг оршин суух газрын хяналт.

5. ХОЛБОГДОХ СТАНДАРТ, УЯЛДАА ХОЛБОО

Бүх үйл ажиллагаа, ОТГУ-н үйл ажиллагаанд дагаж мөрдөх холбогдох стандартуудын (Төслийн стандарт) бүрэлдэхүүнд:

- Монгол улсын холбогдох хууль тогтоомж, стандартууд;
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний (БОНБНО) шаардлагууд;
 - Монгол улсын Засгийн газар, төрийн байгууллагуудын өмнө хүлээсэн үүрэг болон шаардлага, нөхцлүүд;
 - Зээлдүүлэгчийн холбогдох стандарт, журмууд;
 - Рио Тинто ХХК-ийн холбогдох стандартууд;
 - ОТ ХХК биелүүлэхээр үүрэг хүлээсэн салбарын бусад удирдамжууд.

5.1. Монгол улсын холбогдох хууль ба стандартууд

Монгол улсын Үндсэн хуулиар (1992) Монгол улсын иргэн хүссэн газраа амьдрах эрхтэй гэж заасан байдаг. Үндсэн хуулийн дор дотоодын шилжилт хөдөлгөөнийг зохицуулсан олон төрлийн хууль, зохицуулалт болон Засгийн газрын тогтоолууд байдгаас хамгийн их хамааралтайд дараах хуулиуд багтана:

- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, 2006 (2010 онд нэмэлт өөрчлөлт оруулсан);

Шилжилт хөдөлгөөнийг удирдах төлөвлөгөөХүчин төгөлдөр болох огноо:
2017.03.31Баримт бичгийн дугаар:
ОТ-10-PLN-0007-МХувилбар:
2.0

- Иргэний бүртгэлийн тухай хууль, 1999 (2012 онд нэмэлт өөрчлөлт оруулсан).

Бүртгэлийн хууль, журмууд нь шилжилт хөдөлгөөнийг хянан удирдахад зориулагдаагүй, харин бүртгэлийн зорилго нь хүн амын хөдөлгөөнийг бүртгэн, хянахад зориулагдсан байдаг. Түүнчлэн засаг захиргааны нэгжүүд өөрсдийн нутаг дэвсгэрийн хил хязгаарт амьдарч буй хүмүүс, хүн амыг мэдэх, үйлчилгээг төлөвлөх болон татвар хураах үндсэн суурь болдог. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу Монгол улсын газар нутаг нь аймаг, нийслэл, аймаг нь сумдуудад, сум нь багуудад, нийслэл нь дүүргүүдэд, дүүргүүд нь хороодод хуваагдана. Аймаг, сумдуудад олгогддог, орон нутагт нийгмийн үйлчилгээг дэмжих төрөөс хуваарилдаг санхүүгийн дэмжлэг нь бүртгэлтэй хүн амын тоон дээр үндэслэгддэг.

Иргэний бүртгэлийн тухай хуулинд шилжин суурьшигч нь өмнөх оршин сууж байсан газраасаа бүртгэлээ хасуулаад шинээр суурьшиж буй газраа бүртгүүлэхийг заасан байдаг. Засгийн газрын 214-р тогтоолоор “..... 180 хоног түүнээс дээш хугацаагаар өөр газарт суурьшиж буй иргэн нь сум, баг, дүүрэг, хорооны засаг захиргаанд 10 хоногийн дотор бүртгүүлж иргэний үнэмлэхийн хаяганд өөрчлөлт оруулах шаардлагатай”⁴ гэж мөн заасан байдаг. Иргэний оршин суугаа газар нь хуульд⁵ заасны дагуу бүртгүүлсэн засаг захиргааны нэгжээр тодорхойлогдоно.

Шилжилт хөдөлгөөнд хамааралтай эрх зүйн өөр хоёр баримт байдаг нь: 2002 оны Газрын тухай болон 2003 оны Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулиуд юм. Эдгээр нь газар өмчлөх, олгох, ашиглах, шилжүүлэх болон бүртгэх тухай асуудлуудыг зохицуулна.

- 2002 онд баталж, 2012 онд нэмэлт өөрчлөлт оруулсан Газрын тухай хууль нь газартай холбоотой газрын менежмент болон газрын бүртгэлийн асуудлаар төрийн байгууллагуудын эрх мэдлийг шат бүрт нь тодорхойлж өгөхөөс гадна иргэд болон аж ахуйн нэгж байгууллагууд гэрээний үндсэн дээр газар эзэмших, ашиглах асуудлыг зохицуулсан байдаг.
- Иргэд, гэр бүлийн буюу бизнесийн зорилгоор өмчлөх эрх, зарчим, ногдох газрын хэмжээ болон Засгийн газар, нийслэл, аймаг, сумын засаг захиргааны газар олгох, өмчлөх эрх, үүргийн талаар 2003 онд баталж, 2011 онд нэмэлт өөрчлөлт оруулсан Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд заасан байдаг. Газар өмчлөгчөөс тухай өмчлөгчийн газрыг бусад иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд гэрээний үндсэн дээр эзэмшиж болно.

Монгол улсын иргэн бүр (нас харгалзахгүйгээр) газар эзэмшиж, өмчлөх тухай хуулийн (700 кв.м үнэ төлбөргүй) зохицуулалт нь хот суурин газрын төлөвлөлт, хөгжилд ихээхэн нөлөөтэй байгаа юм. Одоогийн оршин суугаа газраас өөр байрлалд үнэ төлбөргүй газар өмчлөх эрхээ иргэд хэдийнээ эдлээд эхэлсэн. Зарим нь эдийн засгийн үйл ажиллагаа өргөжиж байгаа учраас хотуудад газар аваад эхэлсэн байна. Тэдгээр газар өмчлөн авсан хүмүүс уг газарт амьдрахгүй, буюу ойрын үед амьдрах төлөвлөгөөгүй гэж ойлгож болно. Тэдгээрийн ихэнх нь газрын эрэлт хэрэгцээ их болж үнэд орох үед буцаан зарахын тулд газраа хадгалж байна. Зарим нь түрээслэх байшин барих буюу гэр барьж болох юм.

Оюу Толгой компанийн бүтээн байгуулалтын үйл ажиллагаанд зориулагдсан талбайгаас бусад газар нутагт газрын наймаа, ашиг олох үйл ажиллагаанд хяналт тавих боломжгүй тул ялангуяа одоогийн барилга байгууламж баригдаж байгаа болон төлөвлөгдсөн талбайн ойр хавийн газарт явагдах бүтээн байгуулалт, арилжаа наймааны дарамт үйл ажиллагааны шатанд үргэлжлэх хандлагатай байна. ОТ газрын наймааг шууд удирдан хянах боломжгүй ч, газрын наймаатай холбоотой үүсч болох сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах асуудлаар сум ба аймгийн засаг захиргааны байгууллагатай идэвхитэй хамтран ажиллахаа цаашид ч үргэлжлүүлэх бөгөөд

⁴ Монгол улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам (ЗГ-ын 2007 оны 263 тоот тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулсан)

⁵ Иргэний хуулийн 22.1-р зүйл, 2002

Шилжилт хөдөлгөөнийг удирдах төлөвлөгөөХүчин төгөлдөр болох огноо:
2017.03.31Баримт бичгийн дугаар:
ОТ-10-PLN-0007-МХувилбар:
2.0

хашаалсан газар, байшинг хиймэл дагуулаас авсан зурагнаас тоолсон дүнгээс харахад төдийлөн өргөн тархаагүй нь харагдаж байна⁶.

2010 оны “Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай” 140-р тогтоолд хамаарахгүй газар нутгийн хувьд бүсчилсэн гэрээг орон нутгийн засаг захиргаатай байгуулсаны үндсэн дээр хэрэгжүүлэх боломжтой. Ханбогд суманд хүн ам суурьшсан болон ирээдүйд суурьших нутаг дэвсгэрийн байршлын бүсчилсэн төлөвлөгөө нь АХБ-ны дэмжлэгтэйгээр Зүүн өмнийн говийн хот суурин газар, хил орчмын төслийн хүрээнд хийгдэх Ханбогд сумын мастер төлөвлөгөөнд тусгагдах ба энэхүү төлөвлөгөөг Барилга, хот байгуулалтын яам боловсруулах юм.

5.2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний шаардлага

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг 1998 онд баталж, 2001 онд нэмэлт өөрчлөлт оруулсан. 2012 онд оруулсан нэмэлт өөрчлөлт нь уурхай зэрэг том хэмжээний, цогц иж бүрэн бүтээн байгуулалтын хувьд олон нийтэд мэдээлэхэд тавигдах шаардлагууд хангалтгүй байсныг тогтоосон. Нэмэлт өөрчлөлтөөр байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс зайлсхийх, мөн хөрөнгө оруулагчид, бүтээн байгуулагчдын үүрэг, хариуцлагыг маш тодорхой тогтоох заалтыг нэмэгдүүлсэн.

Шинэчлэн найруулсан хуулинд үнэлгээ хийх үйл явцыг ерөнхийд нь ижил хэвээр үлдээсэн хэдий ч, стратеги, бодлого, төлөвлөлт, олон нийтийн зөвлөлдөх уулзалт, удирдлагатай холбоотой шаардлагуудыг хүчтэй болгож өгсөн байна. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийх үйл явцын гол агуулга нь байгаль орчинд үзүүлэх хохирлыг хамгийн бага түвшинд байлгах, байгалийн тэнцвэрт байдал болон биологийн олон янз байдлыг алдагдуулахгүй байх явдлыг баталгаажуулахад оршино. Шинэчлэн найруулсан хууль нь түүнчлэн, яамны цахим хуудсаар дамжуулан аливаа төслийн байгаль орчны стратегийн үнэлгээнд иргэд оролцох боломжийг олгож байгаа ба байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд орон нутгийн засаг захиргаа, иргэд оролцож, өөрсдийн санал бодлыг хүргэх нөхцлийг бүрдүүлээд байгаа юм. Цаашлаад шинэ хуулинд хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ болон бүсийн хэмжээний нөлөөллийг тооцон үзэх зэрэг заалтууд мөн тусгагдсан байна.

5.3. ОТ –н Хөрөнгө оруулалтын гэрээ

2009 оны 10-р сард Айвенхоу Майнз (Туркойз хилл ресурс), Оюу толгой ХХК болон Рио Тинто компаниуд Монгол улсын Засгийн газартай Хөрөнгө оруулалтын гэрээ (ХӨОГ)-г байгуулсан. ХӨОГ-нд бүс нутаг болон төрийн эрх бүхий байгууллагуудын оролцоотойгоор бүс нутгийн хөгжилтэй холбоотой тодорхой шаардлагуудыг оруулсан байна. Энэ тухай гэрээний 4-р бүлэг (Бүс нутгийн хөгжил) болон 4.1, 4.3 болон 4.4-т тусгайлан заасан болно;

Засгийн газар нь “Өмнийн говийн бүсийн хөгжлийн Зөвлөл” /цаашид “Зөвлөл” гэх/-ийг байгуулж үйл ажиллагааг нь удирдан чиглүүлнэ. Хөрөнгө оруулагч нь (ОТ) Удирдах зөвлөлийн гишүүн байх бөгөөд Зөвлөл, түүний үйл ажиллагааг дэмжинэ. Зөвлөл нь Өмнийн говийн бүс, орон нутгийн хөгжлийн стратеги, төлөвлөгөө болон төсвийг боловсруулах, санхүүжүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулахад Засгийн газарт дараах чиглэлээр туслалцаа үзүүлнэ:

1. Орон нутгийн болон бүсийн хөгжил, ил тод, хариуцлагатай засаглалыг дэмжих;
2. Шилжин суурьших хөдөлгөөнийг зохицуулах;
3. Хот төлөвлөлт, хот байгуулалт, түүний дотор эрчим хүч, зам харилцаа, усан хангамж, дулаан, бохир усны асуудлыг шийдвэрлэх.

⁶ Оюу Толгой төсөлтэй холбоотой шилжилт хөдөлгөөнийг удирдах төлөвлөгөөг шинэчлэх зорилгоор Газарзүйн мэдээллийн системийн өгөгдөлд тулгуурлан Ханбогд сумын төвийн нийгэм-газарзүйн өөрчлөлтийг судалсан суурь судалгаа, 2017 оны 2-р сар – тайланг үзнэ үү

Шилжилт хөдөлгөөнийг удирдах төлөвлөгөөХүчин төгөлдөр болох огноо:
2017.03.31Баримт бичгийн дугаар:
ОТ-10-PLN-0007-МХувилбар:
2.0

2012 оны 12 дугаар сард Монгол улсын Засгийн газраас Зөвлөлийн бүтцийг өөрчлөн зохион байгуулах тогтоол гаргасан ч 2013 оноос хойш үйл ажиллагаа явуулаагүй байгаа. ОТ Зөвлөлийн ирээдүйд хийх аливаа ажлыг бүрэн дэмжиж ажиллах болно.

Хамтын ажиллагааны гэрээний хүрээнд (доороос харна уу) ОТ шилжилт хөдөлгөөнтэй холбоотой болон бусад асуудлаар холбогдох аймаг, сумын засаг захиргаатай идэвхитэй хамтарч ажиллаж байна.

5.4. Холбогдох олон улсын стандарт, журмууд

Олон улсын санхүүгийн корпорацийн (ОУСК) Нийгэм, байгаль орчны тогтвортой байдлын бодлого болон гүйцэтгэлийн стандартад (2006) нийгэм, байгаль орчны нөлөөлөл түүний дотор шилжилт хөдөлгөөнтэй холбоотой нөлөөллийг удирдан зохицуулах өргөн хүрээний санал зөвлөмжийг тусгасан. Холбогдох гүйцэтгэлийн стандартууд нь:

- Гүйцэтгэлийн стандарт 1: Нийгэм, байгаль орчны үнэлгээ ба менежментийн систем;
- Гүйцэтгэлийн стандарт 4: Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа ба аюулгүй байдал;
- Гүйцэтгэлийн стандарт 5: Газар чөлөөлөлт ба албадан нүүлгэн шилжүүлэлт.

Оюу Толгой нь одоогийн үйл ажиллагаа болон ОТГУ-н төслийг хэрэгжүүлэхдээ эдгээр стандартын шаардлагыг мөрдөж ажиллана. Хүн амын шилжилт хөдөлгөөний менежментэд хэрэглэгдэх ОУСК-ийн удирдамж нь 2009 оны “Төсөл ба хүмүүс: Төслийн нөлөөллөөр үүсэх хүн амын шилжилт хөдөлгөөнийг зохицуулах гарын авлага” болно. Энэхүү удирдлагын төлөвлөгөөг уг гарын авлагад орсон зөвлөмжүүдийг харгалзан үзэж боловсруулав.

Европын сэргээн босголт хөгжлийн банк (ЕСБХБ)-ны хөрөнгө оруулж буй төслүүд нь тэдний Байгаль орчин ба нийгмийн бодлого (2008 он)-ыг баримталдаг бөгөөд энэхүү бодлогод нийгэм, байгаль орчны нөлөөллийг удирдах асуудлаарх дараах тусгай шаардлагууд тавигдсан байдаг. Эдгээрт:

- Гүйцэтгэлийн шаардлага 1: Байгаль орчин, нийгмийн үнэлгээ ба менежмент
- Гүйцэтгэлийн шаардлага 4: Орон нутгийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа ба аюулгүй байдал
- Гүйцэтгэлийн шаардлага 5: Газар чөлөөлөлт, албадан нүүлгэн шилжүүлэлт ба эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлт.

ОТ нь ЕСБХБ-ны бодлого, гүйцэтгэлийн шаардлагуудад нийцүүлэн ажиллана.

5.5. Рио тинто болон ОТ-н холбогдох стандартууд*Бидний ажлын арга барил*

Рио Тинто компани нийгмийн гүйцэтгэлийг хэрэгжүүлэх өндөр шаардлага бүхий стандарт мөрдөж ажилладаг бөгөөд бизнесийн бүхий л үйл ажиллагаа, хэргэжүүлдэг туршлага нь “Бидний ажлын арга барил” хэмээх баримт бичигт тусгагдсан байдаг. Энэхүү баримт бичиг нь монгол, англи хэлээр цахим хуудсанд тавигдсан болно.

Рио тинтогийн орон нутаг, нийгмийн гүйцэтгэлийн талаар баримтлах бодлого, стандарт

Рио Тинто компани нь Олон нийт болон нийгмийн асуудлын менежментийн иж бүрэн бүтэц, зарчимтай бөгөөд түүнийгээ Рио Тинтогийн удирддаг бизнесийн хувьд ОТ-д ч мөн хэрэгжүүлдэг. Рио Тинтогийн “Орон нутгийн стандарт” –ыг 2015 онд шинэчлэн боловсруулсан бөгөөд Рио Тинто компани нөлөөлөлд өртсөн нутгийн иргэдтэй ажиллан, мэдээлэл цуглуулж, түгээж нийгмийн нөлөөллийг удирдах төлөвлөгөө болон хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх арга замыг

Шилжилт хөдөлгөөнийг удирдах төлөвлөгөөХүчин төгөлдөр болох огноо:
2017.03.31Баримт бичгийн дугаар:
ОТ-10-PLN-0007-МХувилбар:
2.0

тодорхойлсон байдаг. Стандартын тусгай элементүүд нь ОТ-д үүсэж болох хүн амын шилжилт хөдөлгөөнтэй холбоотой асуудлыг удирдахад чиглэгдсэн байдаг. Үүнд:

- Орон нутаг, гүйцэтгэлийн төлөвлөгөө (Оюу Толгойн үйл ажиллагааны хүрээнд хийгдэж буй орон нутагтай холбоотой бүх ажлууд);
- Орон нутгийн нийгмийн суурь үнэлгээ;
- Харилцан зөвшилцөж, ойлголцсон зөвлөлдөх журам;
- Бизнесийн нийгмийн нөлөөллийг ойлгох, удирдан зохицуулах, хянах;
- Орон нутгийн асуудлаарх санал санаачлага, туслалцаа;
- Соёлын өвийн менежмент;
- Гомдол, маргаан, зарга шийдвэрлэх журам;
- Хүний эрхийг хамгаалах;
- Орон нутагтай хийсэн гэрээнүүд.

Рио Тинтогийн орон нутгийн асуудлаар хэрэгжүүлдэг стандартуудын талаарх мэдээллийг Рио Тинтогийн цахим хуудаснаас⁷ үзэх боломжтой.

ОТ-н мөрдөж ажиллахаар үүрэг хүлээсэн үйлдвэрлэлийн салбарын бусад удирдамжууд

Монгол улс, Олборлох үйлдвэрийн ил тод байдлын санаачлагад (ОУИТБС) гарын үсэг зуран нэгдэж орсон орны хувьд байгалийн баялагийн нөөцийг эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах хөдөлгөх хүч байдлаар зүй зохистой ашиглан тогтвортой хөгжлийг бий болгох, ядуурлыг бууруулахад хувь нэмэр оруулахуйц хэрэгжилтийг хангахад Засгийн газар үүрэг хүлээдэг.

ОТ-н үүрэг нь засгийн газар болон бусад талуудад бүх төлбөрөө ил тод төлж, Олборлох салбарын ил тод байдлын санаачлагын зорилго болон одоогийн мөрдөгдөж буй хууль тогтоомж, гэрээний хүрээнд төрийн санхүүгийн удирдлага болон хариуцлагыг сайжруулах замаар Засгийн газрыг дэмжих явдал юм. Мөн ОТ нь ОУИТБС –тай холбоотой үйл ажиллагааны төлөвлөлт, хяналт, үнэлгээ хийх чиглэлээр идэвхитэй хамтран ажиллах байдлаар ОУИТБС-ын асуудалд иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлдэг.

5.6. ОТ- Өмнөговийн Хамтын ажиллагааны гэрээ (ХАГ)

2011 оны 4 дүгээр сард өргөн хүрээг хамарсан зорилтуудыг тусгасан Харилцан ойлголцлын санамж бичиг (ХОСБ) – т Өмнөговь аймаг, Ханбогд сум болон Оюу толгой ХХК гарын үсэг зурснаар ОТ-н Хөрөнгө оруулалтын гэрээний нэг нөхцөл болох ОТ Өмнөговийн Хамтын ажиллагааны гэрээ байгуулах үйл явц албан ёсоор эхэлсэн. Дараа нь 2012 оны 9 дүгээр сард орон нутгийн түвшний гэрээ байгуулах шилдэг туршлагад нийцүүлэн хэлэлцээр хийх зарчмууд болон үндсэн журмуудыг тусгасан Үйл явцын гэрээг үзэглэсэн.

Үйл явцын гэрээний хүрээнд нэлээн хэмжээний гэрээ хэлэлцээр хийсний дараа Өмнөговь аймаг, Ханбогд, Манлай, Баян-Овоо, Даланзадгад сумдын засаг дарга нар болон Оюу толгой ХХК-ийн Ерөнхийлөгч бөгөөд Гүйцэтгэх захирал бүрэн хэмжээний Хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурсан. Бусад харилцан тохиролцсон тодорхойлолтуудын хамт ХАГ-нд Ханбогд, Манлай, Баян-Овоо, Даланзадгад сумдыг ОТ-н түншлэгч сумд гэж тодорхойлсон. МУ-ын БОНБНҮ, зээлдүүлэгчийн БОННҮ болон шилжилт хөдөлгөөнийг удирдах төлөвлөгөөний өмнөх хувилбарууд зэрэг гуравдагч талын баримт бичгүүдэд “Шууд нөлөөллийн талбай”, “Шууд бус нөлөөллийн талбай” гэж заасан үгийг орлоно.

⁷ www.riotinto.com/documents/Communities_standard.pdf

Шилжилт хөдөлгөөнийг удирдах төлөвлөгөө

Хүчин төгөлдөр болох огноо:
2017.03.31

Баримт бичгийн дугаар:
ОТ-10-PLN-0007-М

Хувилбар:
2.0

ХАГ-нд ОТ, Өмнөговь аймаг болон түншлэгч сумд харилцан хүлээсэн үүрэг, түншлэгч сумдын тогтвортой хөгжилд чиглэсэн урт хугацааны үүрэг амлалтын хүрээнд хэрхэн хамтарч ажиллахыг заасан. ХАГ-ний хэлэлцээрийн явцад доорх сэдвүүдийг түншлэгч сумдын хувьд тулгамдсан асуудал гэж тодорхойлсон бөгөөд эцэслэн зурсан ХАГ-нд тохиролцож, Хавсралтаар оруулсан хамтын засаглалын протоколтой хамт өргөн хүрээг хамруулан хэлэлцсэн:

- Усны менежмент – Хавсралт 4
- Байгаль орчны хяналт, хамгаалалт – Хавсралт 5
- Уламжлалт мал аж ахуй, бэлчээрийн менежмент – Хавсралт 6
- Үндэсний түүх, соёл, аялал жуулчлал – Хавсралт 7
- Нийгмийн суурь үйлчилгээ (эрүүл мэнд, соёл, боловсрол, мэргэжлийн сургалт, ажил эрхлэлт– Хавсралт 8
- Орон нутгийн бизнесийн хөгжил, бараа үйлчилгээ худалдан авалт – Хавсралт 9
- Нийтийн зориулалттай дэд бүтцийн байгууламж болон хөрөнгө оруулалтын төслүүд – Хавсралт 10

8, 9 болон 10-р хавсралтууд шилжилт хөдөлгөөний удирдлагатай тусгай уялдаа холбоотой.

Хамтын ажиллагааны гэрээний засаглал

Хамтын ажиллагааны гэрээний харилцааны хороо (ХАГХХ) нь ОТ-н 4 удирдах ажилтан/албан тушаалтан болон түншлэгч сумд, орон нутгийн засаг захиргааны 9 удирдах албан тушаалтнаас бүрдэх ба ОТ, түүний түншлэгч сумдын хоорондын харилцааг хянах үндсэн үүрэгтэй. ХАГХХ нь жилд дөрвөн удаа хуралдаж, түншлэгч сумдад шууд нөлөөлж буй, нөлөөлж болзошгүй ОТ-н ирээдүй, одоо, өнгөрсөн үеийн үйл ажиллагааны талаар хэлэлцэж, хянан үздэг. Ажлын нэг чухал чиглэл нь ОТ-н орон нутгийн бүх харилцаа холбооны талаар бүрэн цогц, ил тодоор авч үзэхэд оршино. Үүнтэй холбоотойгоор ОТ-н зарим менежер, ажилтнууд ХАГХХ-нд үе үе тайлан тавина. Энэ нь түншлэгч сумдын төлөөлөгчидтэй шилжилт хөдөлгөөний удирдлагын талаар хэлэлцэж, сөрөг нөлөөллийг багасгах хувилбар, харилцан хүлээх үүрэг хариуцлагыг хамтран тохиролцож, үр дүнг тайлагнах форум юм. Бүс нутгийн хүн амзүйн чиг хандлага, шилжилт хөдөлгөөний удирдлага нь байнгын хэлэлцэх асуудал байна.

ХАГХХ-ны ажлын бас нэг чухал хэсэг/чиглэл нь Хөгжлийг дэмжих сан (ХДС)-д ирүүлсэн материалыг хянан үзэж, санхүүжилтийн материалын нийцэл болон ОТ, түншлэгч сумдын урт хугацааны хөгжлийн чиглэл, хамтын алсын хараатай уялдуулан үнэлгээ хийсэн дүнгийн талаар ХДС-гийн Удирдах зөвлөлд санал зөвлөмж өгнө.

ХДС-гийн Удирдах зөвлөл нь ОТ-н 4 удирдах албан тушаалтан, түншлэгч сумд болон Өмнөговийн 4 удирдлагаас бүрдэнэ. ХДС нь түншлэгч сумдыг хөгжүүлэхэд зориулан жил бүр ОТ-гоос гаргадаг санхүүжилтийг удирдан зохицуулдаг. Тус сан нь жилд дөрвөн удаа хуралдаж, түншлэгч сумдын засаг захиргаа, байгууллагуудаас ирүүлсэн орон нутгийн төсөл, хөтөлбөрийн саналтай танилцаж, хянан үздэг. 2-р зурагт энэхүү засаглалын уялдаа холбоог харуулав.

Зураг 2. Засаглал: Харилцааны хороо болон Хөгжлийг дэмжих сан

Зөвлөх баг		Удирдлагын баг
Харилцааны хороо (ХХ) <ul style="list-style-type: none"> • ӨГ аймгийн төлөөлөгч-9 • ОТ-н төлөөлөгч – 4 	1. Ач холбогдлоор нь эрэмбэлсэн төслийн саналуудыг ирүүлэх 2. Тайлагнах, шийдвэрийн талаар мэдээлэх 3. Хяналт тавьж, хариу өгөх	Хөгжлийг дэмжих сан Удирдах зөвлөл <ul style="list-style-type: none"> • ӨГ аймгийн төлөөлөгч-3 • ОТ-н төлөөлөгч – 4 Итгэмжлэгдсэн зөвлөх
Ажлын хэсэг <ul style="list-style-type: none"> • Ханбогдын Гурван талт зөвлөл/малчдын бүлэг • Соёлын өв • Нийгмийн суурь 		Хөгжлийг дэмжих сангийн Гүйцэтгэх захирал (санал өгөхгүй)

Шилжилт хөдөлгөөнийг удирдах төлөвлөгөө

Хүчин төгөлдөр болох огноо:
2017.03.31

Баримт бичгийн дугаар:
ОТ-10-PLN-0007-М

Хувилбар:
2.0

<p>үйлчилгээ</p> <ul style="list-style-type: none"> • Бизнесийн хөгжил • Дэд бүтэц <p>Саналуудыг хянан үзэж, зөвлөгөө өгөх</p>		
	<p>Орон нутгийн иргэд</p> <ul style="list-style-type: none"> • Нутгийн иргэд • Нийгмийн бүлгүүд • ТББ • Орон нутгийн аж ахуйн нэгж • Сумын захиргаа • Аймгийн захиргаа <p>Төсөл санаачлагч, хэрэгжүүлэгчид</p>	<p>Нийт санхүүжилтийн хуваарилалт</p> <ul style="list-style-type: none"> • Нийгмийн дэд бүтцийн төслүүд • Тогтвортой хөгжлийн хөтөлбөр • Хандив, санхүүжилт • Хойч үе сан • Захиргааны зардал

ХАГХХ болон ХДС нь хамтдаа ХАГ-ний засаглалын тэнцвэртэй байдал, хэрэгжилтэд хяналт тавьж, хөгжлийн төлөөх хамгийн шилдэг саналуудад дэмжлэг үзүүлж, тэдгээрийг амжилттай хэрэгжүүлэхэд шаардлагатай зөвлөгөө авах, засгийн газрын хөтөлбөрүүдтэй холбоход анхаарч ажилладаг. ХАГХХ болон ХДС-гийн дүрэм, журам нь олон нийтэд хүртээмжтэй байх ба ХДС-гийн Удирдах зөвлөл нь бүх батлагдсан санхүүжилтэд зөвшилцлийн гэрээ байгуулахыг зорьдог. ХДС-гийн санхүүжилтийг сөрөг, төлөвлөөгүй шилжилт хөдөлгөөнийг бууруулахад туслах төсөл, хөтөлбөрт чиглүүлэхийн зэрэгцээ өгөгдсөн санхүүжилт, зохих засаглалын процессийг дагаж мөрдөх ёстой. Өөрөөр хэлбэл, тухайн төсөл, хөтөлбөрийг ОТ болон түншлэгч сумдын төлөөлөгчид бүгд зөвшөөрөн батласны дараа ХДС-гаас санхүүжилт олгоно.

Үүнтэй холбоотойгоор, Ханбогд сумын хот төлөвлөлтийн талаар ХАГ-ний 6-д:

Ханбогд сумын хот төлөвлөлтийн асуудлыг Ханбогд сум нь энэхүү Гэрээнээс тусад нь авч үзэхийг Талууд харилцан зөвшөөрөв. Энэхүү Гэрээний дагуу Талууд Ханбогд сумын хот төлөвлөлтөнд хувь нэмэр оруулах буюу хот төлөвлөлтийг хийх үүрэг хүлээгээгүй. Гэхдээ ХДС-аас баталсан Төсөл, Хөтөлбөрийг (ХАГ-ний 8, 9 болон 10-р сэдэвчилсэн хавсралттай холбоотой) дэмжиж, хэрэгжүүлэх замаар Ханбогд сумын хот төлөвлөлтөд хувь нэмэр оруулж болно гэж заасан.

Шилжилт хөдөлгөөний удирдлага нь түншлэгч сумд, орон нутгийн засаг захиргааны ХАГ-ний дагуух оролцоог харгалзахгүйгээр ОТ-н хүлээсэн үүрэг хэдий ч, дээрх талуудыг бүрэн оролцуулсан нөхцөлд л шилжилт хөдөлгөөний удирдлагыг хамгийн үр дүнтэй хэрэгжүүлэх боломжтой.

6. ӨНӨӨГИЙН НИЙГМИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

1.1 Хүн амзүйн чиг хандлага

Ханбогд сумын төв нь ОТ-н БОННБУ-нд шилжилт хөдөлгөөнд өртөх байршил хэмээн тодорхойлогдсон. Энэ нь ОТ уурхайтай хамгийн ойр байрлах суурин газар бөгөөд уурхайн талбайгаас зүүн хойш 42 км-т оршдог, ОТ-той хатуу хучилтгүй боловч сайн арчилгаатай шороон замаар холбогддог (засмал зам тавих ажлыг эхлүүлсэн бөгөөд 2018 оны сүүлээр дуусах төлөвтэй байна).

Өнгөрсөн арван жилийн турш Ханбогд сумын хүн амын тоо үнэмлэхүй утгаараа мөн Манлай, Баян-Овоо сумдтай харьцуулсан байдлаар тооцоход ч тогтмол өсч ирсэн. 2010 оны хүн амын тооллогоор сумын төвд 1,455 хүн оршин суудаг ба сумын нийт хүн ам нь 3,522 байсан бол 2015 онд

Шилжилт хөдөлгөөнийг удирдах төлөвлөгөө

Хүчин төгөлдөр болох огноо:
2017.03.31

Баримт бичгийн дугаар:
ОТ-10-PLN-0007-М

Хувилбар:
2.0

сумын нийт хүн амын тоо 5,344⁸ болж нэмэгдсэн (бүртгэлгүй оршин суугчид болон ОТ-н кемпэд байрладаг оршин суугчдыг оруулаагүй).

Хүснэгт 2: Түншлэгч сумдын орон нутгийн хүн амын статистик үзүүлэлт 2011 - 2015

Сум	2011	2012	2013	2014	2015	Дундаж өсөлт
Баян - Овоо	1,658	1,712	1,723	1,706	1,716	0.8%
Манлай	2,460	2,530	2,522	2,522	2,481	0.2%
Ханбогд	3,948	4,300	4,712	5,057	5,344	7.4%
Даланзадгад	19,396	20,376	21,581	22,187	23,298	4.5%

Эх сурвалж: Өмнөговь аймаг, жилийн статистикийн мэдээ

Хүснэгт 3: Ханбогд сумын хүн амзүйн чиг хандлага 2008 - 2015

Ханбогд сумын хүн амын үндсэн үзүүлэлт	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015
Хүн амын хэмжээ	3,041	3,154	3,522	3,948	4,300	4,712	5,057	5,344
Хү амын өсөлтийн хурд	2.3%	3.8%	11.6%	12.1%	8.9%	9.5%	7.3%	5.7%
Эрэгтэй	1,474	1,562	1,753	1988	2162	2,373	2,538	2,740
Эмэгтэй	1,567	1,594	1,769	1960	2138	2,339	2,519	2,604
Өрх	918	967	1,112	1,330	1,450	1,590	1,639	1,669
Малчин өрх	496	494	480	478	385	367	364	368
Хөдөөгийн малчид	хамаарахгүй	1,793	2,067	1675	1408	1395	1,359	1,064
Сумын төвийн оршин суугчид	хамаарахгүй	1,363	1,455	2273	2892	3,317	3,698	4,280
Өрхийн дундаж хэмжээ	3.3	3.2	3.2	3	3	3	3.1	3.2

• Эс сурвалж: Өмнөговийн Статистикийн хэлтэс, 2015

6.1. Хүн амзүйн судалгаа шинжилгээ

2011 онд ОТ-н барилгын эхний шатны оргил үед Ханбогд сумын хүн амын өсөлт дээд цэгтээ буюу 13%-д хүрсэн. 2017-2020 онд үргэлжлэх ОТГУ-н барилгын ажлын явцад дээрхтэй ижил хэмжээний эрчимжилт, цар хүрээтэй эдийн засгийн үйл ажиллагаа явагдахгүй тул Ханбогд суманд өөр томоохон олборлолтын төсөл зэрэг ОТ-той холбоогүй өсөлтийн хүчин зүйл гарч ирэхгүй л бол хүн амын өсөлт 2011-2012 оны түвшингээс бага байх төлөвтэй байна.

Ханбогд сумын хүн ам зүйн мэдээллийг задлан шинжилбэл, 2008 оноос хойшхи 7 жилийн хугацаанд өөрсдийгөө малчин өрх хэмээн тодорхойлох гэр бүл, мөн өөрийгөө хөдөөний малчин хэмээн тодорхойлох хувь хүний тоо бараг 30%-иар буурсан нь харагдаж

⁸ Өмнөговь аймгийн нийгэм-эдийн засгийн үзүүлэлтүүд, Статистикийн мэдээ, 2015

Шилжилт хөдөлгөөнийг удирдах төлөвлөгөөХүчин төгөлдөр болох огноо:
2017.03.31Баримт бичгийн дугаар:
ОТ-10-PLN-0007-МХувилбар:
2.0

байна (~130 өрх, ~700 хувь хүн). Өрхийн судалгаа болон албан бус баримтаар тэдгээр хүмүүсийн ихэнх нь Ханбогд сумын төв рүү нүүснээр тухайн хугацаанд сумын төвд нэмэгдсэн оршин суугчдын 25 хувь нь Ханбогдын уугуул иргэд, 75 хувь нь (~ 2,200 хүн) гаднаас нүүж ирэгсэд байна.

Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн харьцаа мөн хугацаанд өөрчлөгдөж, 2008 онд эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдээс 6%-иар их байсан бол, 2015 онд эрэгтэйчүүдийн тоо эмэгтэйчүүдээс 5%-иар илүү болсон байна. Энэ харьцаанаас 2008 оноос өмнө сурч боловсрох, ажил хайхаар орон нутгаасаа гадагш явсан эрэгтэйчүүдийн харьцангуй, цэвэр урсгал болон 2008 оноос хойш ОТ-д ажил хайж ирж буй эрэгтэйчүүдийн буцах урсгал харагдаж байна. Хүйсийн харьцаанд орсон энэ өөрчлөлтийг ноцтой, хэвийн бус эсвэл хяналтаас гарсан хэмээн үзэхгүй бөгөөд ялангуяа нэг өрхөд ноогдох ам бүлийн тоо тогтмол букуу дунджаар 3 орчим хүнтэй хэвээр байгаа нь үүнийг батлаж байна.

МУ-ын хүн амын албан ёсны статистик нь зарим нэг талаараа тодорхойгүй байдаг. Өнгөрсөн долоон жилийн хугацаанд явуулсан нийгэм – эдийн засгийн судалгаа, зөвлөлдөөнөөс харахад сүүлийн арваад жилийн хугацаанд Ханбогд сумын малчдын амьдралын хэв маяг өөрчлөгдсөн байна. Сумын зарим оршин суугчидтай хийсэн ярилцлага⁹, ОТ-с айл өрхүүдэд очиж хийсэн судалгаанаас үзэхэд хүмүүс, ялангуяа залуучууд “хот суурин газрын” үйлчилгээ авах боломж, хүртээмж нэмэгдсэнд сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлж байна. 4WD машиний хэрэглээ нэмэгдэж, сумынхаа хамгийн алслагдмал цэгт ч хэдхэн цагийн дотор хүрэх боломжтой болсноор олон айл өрх сумын төвд сууцтай мөн хөдөө гэртэй байна. Өрхийн нэг ба түүнээс дээш тооны насанд хүрсэн гишүүн, ихэвчлэн ээж нар нь сумын төвд хүүхдүүдтэйгээр гэр болон 1-2 өрөөтэй даруухан тоосгон сууцанд амьдарч, бусад насанд хүрсэн өрхийн гишүүд хөдөө гэртээ малаа маллан амьдардаг дүр зураг түгээмэл байна. Тэдгээр иргэд хоёр байршлынхаа хооронд байнга, ихэнхдээ өдөр бүр ирж очдог. Энэ нь Ханбогдын бүртгэлтэй оршин суугчид бүгд сумын төв дээр амьдардаггүй ч, байнга нааш цааш зорчдог тул эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн үйлчилгээг бүгдэд нь хүртээмжтэй хүргэхүйц хүчин чадалтай байх шаардлагатай юм.

Нийгмийн үйлчилгээ үзүүлэх хүчин чадал, шилжилт хөдөлгөөний удирдлагад ихээхэн нөлөөлдөг хүчин зүйл нь статистикийг сумын хүн амын бүртгэлд үндэслэн гаргадаг орших бөгөөд янз бүрийн шалтгааны улмаас энэхүү статистикт хүн амын тоо бодитоор тусдаггүй. Нэг шалтгаан нь ОТ-н зүгээс баримталж буй Өмнөговийг дэмжих бодлогын хүрээнд ажилд орох, эсвэл гэрээ байгуулах үүднээс олон хүн Ханбогдод оршин суухаар бүртгүүлдэг боловч оршин суудаггүйтэй холбоотой. Эдгээр ‘зохиомол оршин суугч’-дын тоог гаргахад хүндрэлтэй бөгөөд 600-800 хүрч ч магадгүй.

Жишээ нь, 2016 оны 2-4 дүгээр саруудад Ханбогд сумд шилжин ирэгсдийн тоо букуу “зохиомол оршин суугч” –дын тоо эрс нэмэгдсэн нь (6.4-с харна уу) ОТ-с гаргасан Ханбогдын оршин суугчдад давуу тал олгосон ажлын байрны зартай холбоотойг нотлох хангалттай баримт байна. Өөрөөр хэлбэл, бүртгүүлэх зорилгоор хэд хоног байрласныг эс тооцвол 2016 оны эхээр шилжилт хөдөлгөөн бодитоор “огцом” нэмэгдээгүй. Энэ хугацаанд түр ирэгсдийн улмаас болон “нутгийн хүмүүст зориулсан ажлын байранд орохыг хүссэн гадныханд” дургүйцсэн нутгийн залуучуудын үйлдэлтэй холбоотойгоор зөрчил, жижиг гэмт хэргийн тоо мөн нэмэгдсэн байна.

Ямар нэг шалтгаанаар орон нутагт бүртгүүлээгүй оршин суугчид ч байна. ‘Зохиомол оршин суугчид’ болон бүртгүүлээгүй оршин суугчид нэг нь нөгөөгөө тодорхой хэмжээгээр нөхөн тэнцвэржүүлж байгаа ч, одоогийн бүртгэлийг ашиглан тэдгээрийн тоог тодорхой гаргах боломжгүй юм. Бүртгэлээс харахад бүртгүүлэгсдийн 42% нь Даланзадгад болон Цогтцэцийгээс, 14% нь Өмнөговийн бусад сумдаас, 24% нь Улаанбаатараас, 20% нь бусад аймгаас иржээ. Ямар ч шалтгаанаар, хаанаас ч ирсэн бай “зохиомол”, жинхэнэ оршин суугч, эсхүл богино хугацаагаар ирэгсэд нь шилжилт хөдөлгөөний нэг хэлбэр бөгөөд удирдан зохицуулах шаардлагатай.

Сайн удирдахад сайн хэмжилт хийх шаардлагатай тул хүн ам зүйн чиг хандлагыг хянах, шаардлагатай үед нь хийх интервенцийг удирдан зохицуулахад шилжилт хөдөлгөөний талаар илүү

⁹ Ярилцлагад "2004 оны нүүлгэн суурьшуулалтын гэрээний гүйцэтгэлийн аудит, 2014", "Ханбогд сумын хүн ам, орон сууцны тооллого, 2013", "Зах зээлийн түргэвчилсэн судалгаа, 2014", "ОТ-н жил тутмын мониторинг, жилээр" зэрэг судалгааны ярилцлага хамаарна.

Шилжилт хөдөлгөөнийг удирдах төлөвлөгөө

Хүчин төгөлдөр болох огноо:
2017.03.31

Баримт бичгийн дугаар:
ОТ-10-PLN-0007-М

Хувилбар:
2.0

бодитой бөгөөд найдвартай мэдээлэл хэрэгтэй болно. Энэ зорилгоор ОТ Ханбогд сумын хашаа, орон сууц, нийтийн дэд бүтцийн байгууламж, оршин суугчдын тоог хянах шинэ аргыг туршсан (7.4-с харна уу). Энэхүү аргаар оршин суух хаягийн бүртгэлийг харьцуулж, хиймэл дагуулаар авсан зургаас байшингийн тоог гаргах, өрхийн гишүүдийн тоог гаргах зэрэг ажлуудыг хийсэн. Эдгээр аргуудыг ашиглан анхан шатны түүвэрлэсэн мэдээлэл бэлэн болмогц хүн ам зүйн чиг хандлагын талаар илүү бодитой мэдээлэлтэй болж, өөр өөр эх үүсвэрээс авсан мэдээллээр хүн ам зүйн хувьд бодит, сөрөг чиг хандлага үүссэн тохиолдолд үр дүнтэй удирдан зохицуулах арга хэмжээ авах боломжтой болно. 2017 оны эхээр туршин хэрэгжүүлсний үр дүнд ОТ цаашдаа ч энэ арга барилыг хэрэглэхээр төлөвлөж байна.

7. НЭГДҮГЭЭР ҮЕ ШАТНЫ ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДЛАГА (2011 – 2016)

1.2 Нэгдүгээр үе шатны шилжилт хөдөлгөөний эрсдэл

Нэгдүгээр үе шатанд ОТ-с үүдэлтэй шилжилт хөдөлгөөнтэй холбоотойгоор сөрөг болон эерэг нөлөөлөлд өртөж болзошгүй хэмээн тодорхойлогдсон, Хоёрдугаар үе шатанд ч хамааралтай хэвээр байх хүчин зүйлсэд дараах зүйлс багтана:

- Орон нутгийн соёлын талаар эрхэмлэдэг үнэлэмж, уламжлалт амьдралын хэв маяг болон засаглалд үзүүлэх нөлөөлөл;
- Орон нутгийн болон өрхийн эдийн засагт үзүүлэх мөнгөний ханшны уналтын нөлөөлөл;
- ОТ-н ажил хөдөлмөр эрхлэлтэй холбоотой зөрчил маргаан;
- Орон нутгийн нийлүүлэгчдэд гарах боломж;
- Нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдалтай (хүмүүс, эд хөрөнгөд халдах гэмт хэрэг нэмэгдэх зэрэг) холбоотой эрсдэл нэмэгдэх;
- Орон нутаг дах барилга байгууламж, дэд бүтэц, төрийн, нийтийн үйлчилгээний дарамт нэмэгдэх;
- Одоогийн нөөц эх үүсвэрт (усны нөөц, бэлчээрийн газар г.м) дарамт учруулах;
- Бусад сум, аймгаас Ханбогд сум руу түлхүү шилжин ирэх хөдөлгөөн;
- Орон нутгийн иргэд болон шилжин ирэгсдийн хоорондын зөрчлийн эрсдэл нэмэгдэх;
- Түншлэгч сумдын оршин суугчдын ертөнцийг үзэх үзэл өргөжин тэлнэ - “гадны” хүмүүсийн шилжин ирэх урсгал одоогийн хөдөөг ялгаатай болгож, орон нутгийн иргэдийн үзэл бодол, мэдлэг өргөжинө;
- Эдийн засгийн өсөлт – ажилчид болон шинээр ирэгсэд орон байр, хоол, хүнс болон бусад хэрэгцээгээ хангах замаар бүс нутгийн эдийн засгийн өсөлтөнд хувь нэмэр оруулна.

1.3 Нэгдүгээр үе шатанд хэрэгжүүлсэн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Нэгдүгээр үе шатны барилгын ажил болон ОТ-н гадаргын ажил эхэлснээр шилжилт хөдөлгөөнтэй холбоотой сөрөг нөлөөллийг бууруулах олон тооны арга хэмжээ, үйл ажиллагаа, төслүүдийг хэрэгжүүлсэн. **1 болон 2-р хавсралтуудад** эдгээр арга хэмжээний дэлгэрэнгүйг, гарсан үр дүнг анхны БОННБҮ-ний үүрэг амлалттай харьцуулан оруулсан. Нэг болон хоёрдугаар үе шатанд аль алинд нь хамаарах шилжилт хөдөлгөөнтэй холбоотой үзүүлэлтүүдийн хураангуйг Хүснэгт 4-д харуулав.

Хүснэгт 4: Шилжилт хөдөлгөөнтэй холбоотой мэдээллийг ГҮҮ-тэй харьцуулсан тойм

ID	АГУ	Зорилго үзүүлэлт	буюу	Бодит үр дүн	Тайлбар
----	-----	------------------	------	--------------	---------

Шилжилт хөдөлгөөнийг удирдах төлөвлөгөө

Хүчин төгөлдөр болох огноо:
2017.03.31

Баримт бичгийн дугаар:
ОТ-10-PLN-0007-М

Хувилбар:
2.0

IM ГГҮ 1	Орон нутгийн иргэдээс хүн амын шилжилт хөдөлгөөнтэй холбоотой гарсан гомдлын тоо, гомдол барагдуулах системд бүртгэгдсэн байдлаар.	Шилжилт хөдөлгөөнтэй холбоотой гомдлын тоог бууруулах	2016 оноос өмнө шилжилт хөдөлгөөнтэй холбоотой бүртгэгдсэн гомдол байхгүй. 2016 онд шилжилт хөдөлгөөнтэй холбоотой гурван гомдол гарсан.	Нэг гомдлыг орон нутгийн осол зөрчлөөр дээш мэдэгдсэн, засах арга хэмжээ, удирдлагын хяналтыг хэрэгжүүлсэн.
IM ГГҮ 2	Энэхүү Шилжилт хөдөлгөөнийг удирдах төлөвлөгөөнд тусгасан шилжилт хөдөлгөөнийг удирдах арга хэмжээтэй зөрчилдсөн буюу хэрэгжээгүй тохиолдлын тоо	Бууруулах, 0-д хүргэх	2016 оны 8 дугаар сарын байдлаар 0.	Хэрэгжиж байгаа
IM ГГҮ 3	Ханбогдыг Оюу Толгойгоос цахилгаанаар хангах системийг суурилуулан, ажиллуулах	2013 оны 1-р улирлын эцэс гэхэд цахилгаан хангамжтай болох	2013 оны 3-р улирал	Түншлэгч сумд 2014 онд төвийн цахилгааны шугамд холбогдсон.
IM ГГҮ 4	ОТ-с Ханбогд руу явах байнгын зам маршрутыг бий болгох	Барилгын ажлыг 2013 онд эхлүүлэх.	2018 онд дуусгах.	Гүйцэтгэгчийг ажиллуулах шатанд үе шатанд байгаа.
IM ГГҮ 5	Бизнесийн паркийн БОННБУ дууссан байх	Барилгын ажил эхлэхээс өмнө БОННБУ дууссан байх	Бизнесийн паркийн барилгын ажлын талаарх шийдвэр хүлээгдэж байгаа.	ОТ болон ХБ-ын удирдлагууд Бизнесийн паркийг Ханбогдыг хөгжүүлэх цогц төлөвлөгөөнд тусгасан.
IM ГГҮ 6	Шилжилт хөдөлгөөн зохицуулах/удирдах хорооны хийсэн хурлын тоо	2013 оны 1-р улирлын эцэсээс эхлэн улирал тутам хийсэн хурал	Өмнөговийн удирдах хороо улирал бүр хуралдаж байгаа	Шилжилт хөдөлгөөн зохицуулах/удирдах хороог Өмнөговийн удирдах хороо орлох болсон (2016 оны 1-р улирлаас)
IM ГГҮ 7	Аймгийн ДНБ-ний хэмжээ	2013 – 2020 онд жилд 20%-иар нэмэгдэнэ	2014 +ve 26%	Аймгийн ДНБ 3-5 жилийн хугацаанд нэмэгдсэн, 2015 онд нүүрсний үйлдвэрлэл буурсны улмаас буурсан; 2015 онд газар тариалан, үйлчилгээний ДНБ +15% болон +7% байсан
			2015 –ve 6%	
IM ГГҮ 8	Аймгийн татварын орлого	2013- 2020 онд жилд 5%-иар нэмэгдэнэ	(16%) 2013	Аймгийн татварын орлого тооцоолсноос илүү байгаа.
			(13%) 2014	
			(16.8%) 2015	

Шилжилт хөдөлгөөнийг удирдах төлөвлөгөө

Хүчин төгөлдөр болох огноо:
2017.03.31

Баримт бичгийн дугаар:
ОТ-10-PLN-0007-М

Хувилбар:
2.0

IM ГГҮ 9	Нөлөөнд өртсөн сумдын ядуурлын баримтжуулсан түвшинг бууруулах	Ядуурлын түвшин жилээс жилд буурна	2012 онд 13% - иар буурсан ТВА 2017	Дараагийн улсын хэмжээний тайлан 2017 онд гарна.
IM ГГҮ 10	Мэргэжлийн боловсрол эзэмших	Мэргэжлийн боловсрол сургалтанд хамрагдах хүний тоо нэмэгдэнэ	2013 онд 743 2014 онд 957 2015 онд 939	3-5 жилийн хугацаанд 2015 онд ОТГУ-н төсөл хүлээгдсэн мөн улсын эдийн засаг буурсантай холбоотойгоор зогсолтонд орсон.
IM ГГҮ 11	ОТ-н орон нутгаас авах/нийлүүлэх бараа, үйлчилгээний хэмжээ	ОТ-н улирал бүр дотоодоос худалдаж авах бараа, үйлчилгээний өртөг (УБ, АГ, ХБ-р хуваасан) Хангамжийн хэлтсийн тогтоосон жилийн зорилтот хэмжээний дагуу өсөж байгаа	2013 онд Өмнөговьд 19 сая ам.доллар 2014 онд Өмнөговьд 43 сая ам.доллар 2016 оны зорилтот 75 сая ам.долларт хүрэх үүднээс 2015 онд Өмнөговьд 66 сая ам.доллар.	2013 онд орон нутгийн оролцооны стратегийг санаачилснаас хойш Өмнөговийн худалдан авалт огцом өссөн. Хэрэгжиж байгаа.
IM ГГҮ 12	Байгуулагдсан жижиг дунд үйлдвэрлэлийн тоо	Ханбогд, Манлай, Баян-Овоо, Даланзадгад сум, Өмнөговь аймагт байгуулагдаж, бүртгүүлсэн (түншлэгчсүмд, шинэ болон үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдээр гаргасан) ЖДҮ-ийн тоо 2013 оны суурь судалгаанд зааснаас нэмэгдэж байна	2013 онд 831 2014 онд 977 2015 онд 1055	Ханбогдод бүртгүүлсэн аж ахуйн нэгжийн тоо 2007-2015 онд 25-с 225 болж нэмэгдсэн. Хавсралт 2-с харна уу.

7.1. Хүн амын бүтцийн тойм 2008 - 2015

Өсөлтийн өнөөгийн чиг хандлагаар Ханбогд сумын хүн ам (Хүснэгт 1) 2023 он гэхэд 8,300 хүрэх магадлалтай байгаа бөгөөд энэ нь 2750 өрхийн¹⁰ 10,200 хүн¹¹ байна гэсэн өмнөх тооцооллоос (БОННБҮ) харьцангуй бага байна. ОТ-н хувьд жилийн дундаж өсөлт 8%-иас бага байхыг (жилд ойролцоогоор 440 хүн нэмж ирнэ) боломжийн түвшинд байна гэж үзэх бөгөөд байгалийн жамаар өсөх, хувь хүний шилжилт хөдөлгөөн хийх сонголтод үндэслэн одоогийн өсөлтийг тогтвортой байлгах боломжтой гэж үзэж байна. Нийгмийн үйлчилгээг иргэдэд хүргэх, дэд бүтэц барьж байгуулахад зарим үед, ялангуяа 2010-2011 онуудад хүндрэл тулгарч байсан ч, ерөнхийдөө хэрэгцээг хангаж чадаж байна. ОТ УБ-с ОИОБ одоогийн ажиллах хүчний хэмжээгээ Өмнөговьд суурьшуулах бодлого баримталж, Ханбогдын хүн амын тоо илүү нэмэгдэх тохиолдолд ОТ нь ХДС-гаар дамжуулан олгох санхүүжилтээс гадна нийгмийн шууд дэмжлэг үзүүлэх шаардлага бий болж магадгүй юм.

¹⁰ Эх сурвалж: 'Ханбогдын нийгэм – эдийн засгийн хөгжлийн хэтийн төлөвлөгөө 2014-2023, Өмнөговь, Ханбогд, 2014

¹¹ Эх сурвалж: АХБ-ны хүн амын төлөвлөлт.

Шилжилт хөдөлгөөнийг удирдах төлөвлөгөөХүчин төгөлдөр болох огноо:
2017.03.31Баримт бичгийн дугаар:
ОТ-10-PLN-0007-МХувилбар:
2.0

2-р хүснэгтэд харуулсанчлан Манлай, Баян – Овоо сумдын хүн амын өсөлт тогтвортой байна. Эдгээр сумдын удирдлага Ханбогдыг дагаад сум нь эзгүйрч хоосорно гэж санаа зовнисоор ирсэн. Өнөөдрийг хүртэл ийм зүйл болоогүй бөгөөд тогтвортой байдал хадгалагдсаар байгаа. Манлай болон Баян – Овоо сум ОТ, Таван толгойн нүүрсний уурхайн бүтээн байгуулалтаас холбогдох дэд бүтэц, ложистикийн хувьд эерэг үр дүн, үр шимийг амсаж байгаа бөгөөд хүн ам тогтвортой байгааг үүгээр тайлбарлаж болох юм. ОТ зарим ажилтнуудаа эдгээр байршлуудад байрлуулахыг зорьж, үүнд зориулсан ажилд авах, хөдөлмөр эрхлэх хувилбаруудыг бий болгохын зэрэгцээ дээрх сумдад хангалттай хэмжээний анхаарал татахуйц нийтийн дэд бүтцийг бий болгож байна (**1 болон 2-р хавсралтаас** харна уу)

ОТ-н гадарга дээрх барилга байгууламжийн ажил, эхний үеийн үйл ажиллагааны хугацаанд Даланзадгадын өсөлтийн хэмжээ 23,000 мянган хүн амтай суурины хувьд жилд дунджаар 4-5 хувь байсан ба ихэнх нь (маш их хэлбэлзэлтэй байсан) ОТ-с илүү Даланзадгадтай ойрхон байсан олон тооны нүүрсний уурхайн бүтээн байгуулалтын ажилтай холбоотой байсан. ОТ шилжилт хөдөлгөөний удирдлагын стратегийнхээ хүрээнд Даланзадгадад ажиллах ажилтнууддаа зориудаар ОИОБ хувилбарыг бий болгож, Ханбогд руу нүүн шилжих байдлыг бууруулсан. Энэ нь ч амжилттай хэрэгжиж байна.

ОТ-н зүгээс шилжилт хөдөлгөөний удирдлага, бүс нутгийн хөгжлийн стратегийг хэрэгжүүлэх замаар түншлэгч сумдын эдийн засгийг хөгжүүлэх, тэлэхэд хувь нэмэр оруулж байгаа бөгөөд эдгээр сумдын хүн амын өсөлтийн өнөөгийн түвшин нь эдийн засгийн өсөлттэй нийцэж байна. Өмнөговь аймгийн Ханбогдоос бусад сумдад тогтворгүй байдал ажиглагдаж байгаа нь нүүрсний уурхайн бүтээн байгуулалтын ажил болон үе үе тасалдаж явагддаг засгийн газрын дэд бүтцийн төслүүдтэй холбоотой бөгөөд үүнтэй харьцуулахад Ханбогд харьцангуй тогтвортой байна.

7.2. Шилжилт хөдөлгөөний хяналт, осол зөрчил, эрсдлийг бууруулах арга хэмжээ 2011 - 2016

2013 онд энэхүү удирдлагын төлөвлөгөөг хэрэгжүүлж эхэлснээс хойш ОТ удирдлагын хяналт, үйл ажиллагаа, төслүүдийн үзүүлэлтүүд болон ерөнхий үр дүнг хянаж ирсэн. 2015 онд төлөвлөөгүй шилжин суурьшилтын шинж тэмдэг илрээгүй байх үед нийгмийн эрсдэлийн үнэлгээг шинэчилж, нийгмийн нөлөөллийн бүртгэлд “гар” буюу зөрүүний шинжилгээ хийсэн. Харин Ханбогдын оршин суугчдыг давуу эрхтэйгээр ажилд авах зар орон нутагт тавигдсаны дараа буюу 2016 оны 3, 4 дүгээр сард Ханбогд суманд оршин суухаар бүртгүүлсэн иргэдийн тоо огцом өссөнөөр (бодитойгоор оршин суудаг эсэх нь баталгаатай бус 6387 хүн бүртгүүлсэн) төлөвлөөгүй шилжилт хөдөлгөөний шинж тэмдгүүд гарч эхлэсэн. 2016 оны 6-р сард нэгэн улс төрийн албан тушаалтны зүгээс орон нутгийн сонгууль болохтой холбоотойгоор уг төлөвлөөгүй шилжилт хөдөлгөөн сонгуулийн саналд нөлөөлж болзошгүй байна гэсэн санал гомдлыг ОТ-д ирүүлсний дагуу уг асуудлыг анхаарч, арга хэмжээ авч эхлэсэн. Тухайн санал гомдол болон оршин суух бүртгэлийн огцом өсөлтийг “нийгмийн осол зөрчил” хэмээн бүртгэж, төлөвлөөгүй шилжилт хөдөлгөөний магадлалыг 3-р зэргийн эрсдэл хэмээн тодорхойлж, дотооддоо удирдлагуудад шатлан уламжилж, удирдах албан тушаалтан болон санхүүжүүлэгчдэд мэдээлсэн. Шилжилт хөдөлгөөнтэй холбоотой хүн амын өсөлтийн судалгаа шинжилгээний үр дүнд оршин суух бүртгэлийн дийлэнх нь ОТ-н орон нутгийн оролцооны бодлогын хүрээнд давуу тал олгосон нөхцлөөр ажилд орох зорилгоор шилжилт хийлгэсэн буюу “зохиомол” бүртгэл байсан нь тогтоогдсон. Хүнд машин механизмын дадлагажигч операторын ажилд Ханбогдын иргэдийг ажилд авах зарыг зөвхөн орон нутагт гарган, ажилд авах хүмүүсийн тоог тодорхой заагаагүй ба зөвхөн Ханбогдын иргэд ажилд орох хүсэлт ирүүлнэ хэмээн тооцоолсон нь бодит байдал дээр ажилд орохыг хүссэн хүмүүс маш олон газраас ирсэн нь уг тооцоо буруу байсныг харуулсан бөгөөд ам дамжсан үг болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл ямар хүчтэй гэдгийг харуулсан жишээ болсон.

Энэ явдал бидэнд үнэтэй сургамж болсон бөгөөд асуудлын гол шалтгаан нь төлөвлөөгүй шилжилт хөдөлгөөн бус, харин мэдээлэл цуглуулах, баталгаажуулах аргад байсан тул ОТ энэ алдаагаа дахин давтахгүйн үүднээс орон нутгийн худалдан авалт, хөдөлмөр эрхлэлтийг хянан үзэж, нийгэм эдийн засгийн мониторингоо сайжруулсан. Жишээ нь, Өмнөговь аймгийн удирдлагуудын зөвлөсний

Шилжилт хөдөлгөөнийг удирдах төлөвлөгөөХүчин төгөлдөр болох огноо:
2017.03.31Баримт бичгийн дугаар:
ОТ-10-PLN-0007-МХувилбар:
2.0

дагуу ОТ-д ажилд орох, гэрээгээр ажиллах ажлын байранд тавигдах шалгуурт Өмнөговьд гурваас доошгүй жил оршин суусан байх гэсэн шаардлагыг нэмсэн.

2017 оны эхээр ОТ хиймэл дагуулын зураг¹² ашиглан орон сууц, хашаа тоолох ажлыг эхлүүлсэн. Энэ тооллогын дүнгээс харахад Ханбогд сумын төвийн барилга байшин, хашааны тоо өнгөрсөн 10 жилийн хугацаанд нэмэгдсэн нь (нэг орон сууцанд амьдарч буй хүний дундаж тоо тогтмол байсан гэж үзсэн) баригдсан дэд бүтцийн барилга байгууламж нэмэгдсэнтэй холбоотойгоор 2010-2013 онд хүн амын өсөлт хамгийн өндөр байсныг батлаж байна. 2013 оноос хойш дэд бүтцийн барилга байгууламж барих нь буурсан бөгөөд 2016 онд хүн амын бүртгэл огцом өссөн ч, орон сууцны тоо нэмэгдээгүй. Судлаачдын мэдээлснээр шилжилт хөдөлгөөнөөс үүдэлтэй ландшафтын болон байгаль орчны тодорхой нөлөөлөл үүсээгүй; хөрөнгө баялаг болон хүн амзүйн онцлог зэргээс шалтгаалан суурьшил шинээр үүсэх асуудал гараагүй. Товчхондоо 2016 онд хүн амын бүртгэл огцом өссөн нь сумын төвд дэд бүтцийн байгууламж нэмэгдсэнтэй холбоогүй юм. Энэхүү бие даасан хяналтыг ОТ-н шилжилт хөдөлгөөний хяналтын нэн чухал хэсэг болгон авч үзэж байгаа бөгөөд оршин суугаа хүн амын тоог бүртгүүлсэн мэдээллээс ангид гаргахын тулд түүвэрлэн гаргасан орон сууцны тоог нийт орон сууцны тооны утгад шилжүүлэн хэрэглэж болно. Хоёрдугаар үе шатны (2017-2019) шилжилт хөдөлгөөний удирдлагын явцад орон сууцны тоо болон гаргасан оршин суух хаяг нь хүн амын бүртгэлтэй харьцуулан шалгахад үнэтэй мэдээлэл болно.

2008 оноос хойш хэрэгжүүлсэн хяналт, үйл ажиллагаа төслүүдийн (Нөлөөллийн удирдлагын төлөвлөгөөний хүрээнд 2013 оноос хойш албан ёсоор хянан удирдаж буй) үр дүнд Ханбогд сум руу (төлөвлөгөөгүй шилжилт хөдөлгөөний улмаас маш их эрсдэлд орсон түншлэгч сум) чиглэсэн шилжилт хөдөлгөөний улмаас нэмэгдсэн хүн амын өсөлтийг жилд 8 хувь буюу түүнээс доош байлгах зорилт хэрэгжсэн. Бусад түншлэгч сумдын хувьд (Манлай, Баян-Овоо, Даланзадгад) хүн амын өсөлт тогтвортой буюу өсөлтийн хэмжээ нь хэвийн, зохицуулах боломжтой байна. Шилжилт хөдөлгөөний удирдлагын стратегийн хүрээнд аливаа хүчин зүйл, элементийг дангаар нь авч үзэх боломжгүй буюу аливаа нөлөөг тодорхой нэг шалтгаанд дангаар нь хамааруулан үзэх боломжгүй ба элемент, хүчин зүйлс нь хоорондоо хамааралтай нэгэн цул болдог.

8. ХОЁРДУГААР ҮЕ ШАТНЫ ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДЛАГА (2017-2019)**8.1. Арга барил**

Хоёрдугаар үе шатанд шилжилт хөдөлгөөнийг зохицуулах ОТ-н арга барилын зорилго нь Өмнөговь аймаг руу чиглэсэн орон нутгийн болон бүсийн хүн амын шилжилт хөдөлгөөнтэй холбоотой болзошгүй сөрөг нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, ингэхдээ Ханбогд суманд гол анхаарал хандуулахад оршино. Нэгдүгээр үе шатны барилгын ажлын дараа Хамтын ажиллагааны гэрээг батласнаар ОТ-н хувьд орон нутгийн харилцаа, тэр дундаа шилжилт хөдөлгөөний удирдлагыг удирдан зохицуулах арга барилд томоохон өөрчлөлт орсон. Өөрөөр хэлбэл, бүс нутгийн нийгэм эдийн засгийн хөгжилтэй холбоотой ОТ-н бүх хөтөлбөрийг ХАГ-ний хүрээнд хэрэгжүүлэх болсон. Тиймээс 2015 онд Орон нутгийн харилцаа хариуцсан хэлтэс орон нутгийн төслийг зөвхөн нэг талаас хэрэгжүүлэн хүргэх арга барилаа өөрчлөн, орон нутагт эрх олгосон арга барилд шилжиж, хэрэгжилтийн удирдлагын хяналтыг аажмаар өөрчилсөн. Үүнд дараах үндсэн зарчмууд хамаарна:

- Тодорхойлсон/илрүүлсэн, шууд сөрөг нөлөөллийг бууруулах удирдлагын хяналтыг ОТ хариуцах бөгөөд өндөр эрсдэлтэй, цаг хугацаа богино байх тохиолдолд нэг талаас хэрэгжүүлэх.
- Ирээдүйн болзошгүй нөлөөллийг бууруулах зорилготой аливаа үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөрийг ӨМУХ болон ХАГХХ-р дамжуулан, ХАГХХ санал болгосон тохиолдолд ХДС-гийн тусламжтайгаар удирдан зохицуулах.

¹² Оюу Толгой төсөлтэй холбоотой шилжилт хөдөлгөөнийг удирдах төлөвлөгөөг шинэчлэх зорилгоор Газарзүйн мэдээллийн системийн өгөгдөлд тулгуурлан Ханбогд сумын төвийн нийгэм-газарзүйн өөрчлөлтийг судалсан суурь судалгаа, 2017 оны 2-р сар – тайланг үзнэ үү

Шилжилт хөдөлгөөнийг удирдах төлөвлөгөөХүчин төгөлдөр болох огноо:
2017.03.31Баримт бичгийн дугаар:
ОТ-10-PLN-0007-МХувилбар:
2.0

- Ирээдүйд үүсч болзошгүй, удирдлагын хяналтын арга хэмжээг төлөвлөөгүй, ХАГ-ний процессээр хэрэгжүүлсэн хөтөлбөрийн хүрээнд хангалттай тусгагдаагүй шууд сөрөг нөлөөллийг бууруулах үүргийг ОТ хүлээнэ.

Эдгээр зарчмуудын хүрээнд заасан нөөц, удирдлагын үүрэг хариуцлагаас үл хамааран шилжилт хөдөлгөөнтэй холбоотой бүх үйл ажиллагаанд дотоод болон хөндлөнгийн аудит явуулна.

8.2. Шилжилт хөдөлгөөний төрөл

Шилжилт хөдөлгөөнийг доорх хоёр ангилалд хуваан авч үзнэ:

- Төлөвлөсөн шилжилт хөдөлгөөн** – Төсөл өөрөө шууд ажилд авсан болон гэрээний нөхцлөөр дундаж буюу харьцангуй өндөр хяналт тавьдаг гэрээт ажиллагсад, ханган нийлүүлэгчдийн ажилтнууд.
- Төлөвлөөгүй** – Ажил хайж, эсвэл үйлчилгээ үзүүлэх болон төсөлтэй холбоотойгоор эдийн засгийн боломж эрэлхийлэн ирсэн хүмүүс.

Төлөвлөөгүй шилжилт хөдөлгөөний асуудлын тухайд, Монгол улсын иргэн хүссэн газраа амьдрах эрхтэйг Монгол улсын Үндсэн хуульд тунхагласан байдаг. Тиймээс уурхайн хашаанаас цааших газар нутагт хүмүүс хаана суурьших асуудлыг ОТ шууд хянаж чадахгүй. Уурхайн хашаанаас цааших нутаг дэвсгэр дээрх суурьшилт, хөгжил, үйл ажиллагаа, нийтийн дэд бүтэц, үйлчилгээ нь зарчмын хувьд Засгийн газрын үүрэг юм. Гэхдээ ОТ-н иргэний дэд бүтцийн чиглэлээр хийж буй ажлууд нь хүмүүсийн хаана амьдрахаа шийдэхэд нь нөлөөлөхийн зэрэгцээ Өмнөговийн ажил эрхлэлт болон орон нутгийн оролцооны стратегиар дамжуулан хүмүүсийг суурьшин амьдрахыг дэмжиж буй нутаг дэвсгэртээ иргэдийн тав тухтай амьдрах нөхцлийг хангахад оруулж буй үнэтэй хувь нэмэр болж байна.

8.3. Зорилт

Ханбогдын хүн амын арван жилийн дундаж өсөлт жилд 8% (жил бүр дунджаар 440 хүн суурьшихаар ирдэг) байгаа нь нийгмийн үйлчилгээний хүртээмжтэй харьцуулахад боломжийн гэж үзэж болно. Мөн Даланзадгадын хүн амын арван жилийн дундаж өсөлт жилд 4-5%, Манлай, Баян-Овоо сумдын хувьд жилд 0-1% байна.

ОТ-н хувьд Өмнөговьд суурьших ажилтнуудынхаа харьцааг 2025 онд одоогийн 22%-иас 50%-д хүргэхийн тулд хэвийн эргэлтээр нь болон шилжүүлэн байрлуулах арга замуудаар жилд дунджаар 320 ажилтан, гүйцэтгэгчийг Өмнөговьд руу шилжүүлэх шаардлагатай болно.

Хүн амын хөдөлгөөнийг энэхүү зөвшөөрөгдөх шилжилт хөдөлгөөний зорилгод нийцүүлэх байдлыг **3, 4 болон 5-р хавсралтад** заасан удирдлага, хяналтаар дамжуулан хянана.

Төлөвлөсөн болон төлөвлөөгүй шилжилт хөдөлгөөний үр дүнд нийт бүс нутгийн хүн амын тоо өснө. ОТ болон түншлэгч сумд нь тус тусдаа болон хамтран хэрэгжүүлж буй хөгжил, нутагшуулах бодлогынхоо хүрээнд хүн амыг ерөнхийд нь нэмэгдүүлэх бодлого баримталж байгаа тул шилжилт хөдөлгөөнийг удирдахдаа дор бүрнээ бичил менежмент хийх бус харин нарийн уялдаа холбоо, зохицуулалт тохиргоо хийх шаардлагатай. Бичил менежментийг төвлөрсөн төлөвлөгөөтэй адил гэж үзэх бөгөөд Монгол улсын үндсэн хуулиараа төвлөрсөн төлөвлөгөөт нийгмээс татгалзсан.

ОТ-с хүлээн зөвшөөрөхүйц, зохицуулах боломжтой шилжилт хөдөлгөөнд хоёр арга замаар нөлөөлөх боломжтой, үүнд: 1) төлөвлөсөн шилжилт хөдөлгөөний зохицуулалт хийхдээ ажилд орох, гэрээ байгуулахад оршин суух газрын шаардлагыг нэмж оруулах; 2) нийт хүн амын хүлээн зөвшөөрөгдөх өсөлтийн хэмжээнд тохирсон эрэлт хэрэгцээг хангахуйц дэд бүтэц, нийтийн үйлчилгээ үзүүлэхэд хувь нэмэр оруулах.

ОТ-н шилжилт хөдөлгөөний удирдлагын аргын үндсэн тулгуур нь хүн амзүйн чиг хандлагыг хянах, энэхүү чиг хандлага нь хүлээн зөвшөөрөгдөх түвшнээс ихээр хазайх тохиолдолд зохих арга хэмжээ авах юм. Удирдлагын төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор энэхүү хүлээн зөвшөөрөгдөх түвшинг:

Шилжилт хөдөлгөөнийг удирдах төлөвлөгөөХүчин төгөлдөр болох огноо:
2017.03.31Баримт бичгийн дугаар:
ОТ-10-PLN-0007-МХувилбар:
2.0

- Ханбогодод жилд 8%-иас бага;
- Манлай, Баян-Овоо сумдад 0-1%;
- Даланзадгадад 5%-иас бага байна гэж тодорхойлсон.

Шилжилт хөдөлгөөний удирдлагаас гадна нийгмийн сайн сайхан, түншлэгч сумдын нийгмийн тогтвортой байдалд хувь нэмэр оруулах замаар урт хугацааны үйл ажиллагаа явуулах нийгмийн зөвшөөрлөө баталгаажуулах үндсэн зорилгынхоо хүрээнд орон нутаг, бүс нутгийн эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах нь ОТ-н хувьд нэн чухал асуудал юм. Энэ зорилгоор ОТ-н шилжилт хөдөлгөөний удирдлагын арга нь дараах зорилтуудтай, үүнд:

- Өмнөговь аймаг болон түншлэгч сумдын засаг захиргаатай хамтран ажиллаж төлөвлөөгүй шилжилт хөдөлгөөнтэй холбоотой нийгмийн тогтворгүй байдлыг бууруулах, тогтвортой хөгжлийг хангах боломжийг бий болгох;
- Төлөвлөөгүй шилжилт хөдөлгөөнийг байнга ажиглах, түншлэгч сумдын хүн амын хөдөлгөөнийг хамтран хянах, ОТ-н орон нутгийн оролцооны бодлогод, туршлагад тохируулга хийх шаардлагатай эсэх, шилжилт хөдөлгөөний чиг хандлагад бүтээлчээр нөлөөлөх нийтийн зориулалттай барилга байгууламж, үйлчилгээнд хувь нэмэр/хөрөнгө оруулалт оруулах шаардлагатай эсэхийг тодорхойлох.
- ОТ-с үүдэлтэй үйл ажиллагаанаас ирээдүйд гарах орон нутаг, бүс нутгийн эдийн засгийг хөгжүүлэх илүү өргөн хүрээг хамарсан боломжуудыг оновчлох.
- Оршин суух газрын бүртгэл “огцом өссөний” улмаас бий болсон нийгэм улс төрийн түр зуурын хурцадмал байдлаас зайлсхийх.

Хүн амын бүртгэл “огцом өсөх” асуудлыг удирдан зохицуулахын тулд орон нутгаас худалдан авалт хийх, орон нутгаас ажилд авах үйл явцад анхааралтай хандаж (8.4-д дурдсанчлан), ажлын зарыг оновчтой, анхааралтай гаргах зэрэг арга хэмжээ авна. Ханбогд дахь олон нийтийн харилцааны ажилтнаар дамжуулан орон нутгийн иргэд болон удирдлагуудтай уулзан ярилцах, оршин суугчдын бүртгэлийн мэдээллийг тогтмол хянах зэрэг арга замаар бүртгэл, шилжилт хөдөлгөөний болзошгүй өсөлтийг байнга биечлэн хянахад илүү анхаарал хандуулж ажиллана.

8.4. Шилжилт хөдөлгөөнийг бууруулах

Төлөвлөөгүй шилжилт хөдөлгөөнийг үр ашигтай удирдан зохицуулахад тулгарч буй гол сорилтууд нь холбогдох мэдээллийн төрлийг зөв тодорхойлох, үнэн зөв/найдвартай мэдээлэл олж авах, ОТ-н нөлөөлөлд өртсөн орон нутагт үүсэж буй хүлээн зөвшөөрөх боломжгүй аливаа тохиолдлын шинж чанар, хамрах хүрээг аль болох хурдан ойлгох/тогтоох, шаардлагатай үед нь холбогдох оролцогч талуудтай бууруулах арга хэмжээг яаралтай боловсруулах, тохиролцох, хэрэгжүүлэхэд оршино. Хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн шилжилт хөдөлгөөний тохиолдлыг Засгийн газар, Өмнөговь аймаг болон түншлэгч сумд ойлгож, хамтарсан арга хэмжээ авах нь чухал.

Өмнөговийн бүсийн хөгжлийн зөвлөл байхгүй тохиолдолд, ОТ шилжилт хөдөлгөөнтэй холбоотой асуудлаар Өмнөговийн захиргаатай хамтарсан хяналт, удирдлагыг хэрэгжүүлэхийн тулд ХАГ-ний хүрээнд байгуулагдсан ӨГУХ болон ХАГХХ-г ашиглана. ХАГХХ нь ОТ болон шаардлагатай тохиолдолд шилжилт хөдөлгөөнийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг холбогдох байгууллагуудад өгөх эрх мэдэл бүхий Өмнөговийн захиргааны удирдах хүмүүсээс бүрдсэн албан ёсны эрх бүхий байгууллага юм.

ОТ-с ОТ-н ашиглалт, ОТГУ-н хэлтсийн удирдах ажилтнуудаас бүрдсэн хэлтэс дамнасан ӨМУХ-г 2015 онд байгуулж, байнгын хэлэлцэх асуудал болох орон нутгийн ажил эрхлэлт, орон нутгийн худалдан авалт, шилжилт хөдөлгөөний удирдлага зэрэг Өмнөговийн асуудлаар стратегийн удирдамж, зааварчилгаа өгөх үүрэг хүлээлгэсэн. ОТ-н Орон нутгийн харилцааны хэлтсийн Ерөнхий менежер ХАГХХ болон ӨМУХ-нд оролцож, дотоод, гадаад засаглалын/удирдлагын хоорондын чухал холбоос болдог. Удирдлагын төлөвлөгөөний засаглал хэсгийн 4.2-д дурьдсанаар 2017 оны 3 дугаар сард ОТ болон Өмнөговийн удирдлага Өмнөговийн түншлэлийн хороо гэж нэрлэгдэх

Хуудас 26, Нийт 62

Шилжилт хөдөлгөөнийг удирдах төлөвлөгөөХүчин төгөлдөр болох огноо:
2017.03.31Баримт бичгийн дугаар:
ОТ-10-PLN-0007-МХувилбар:
2.0

хяналтын шинэ байгууллагыг байгуулахаар тохиролцсон. Талууд засаглалын процессийг тохиролцсоноор ӨГТХ нь 2017 оны эцэс гэхэд ӨМУХ-г бүрэн орлоно.

ӨГТХ-ны анхны уулзалт семинар 3 дугаар сарын 26-27-ний өдрүүдэд Даланзадгадад болсон бөгөөд Өмнөговь аймаг, Ханбогд, Манлай, Баян-Овоо сумдын удирдлага, улс төрийн удирдлагууд болон Оюу толгой, Эрдэнэс оюу толгойн гүйцэтгэх захирал, удирдах хүмүүс оролцсон. ӨМТХ нь шилжилт хөдөлгөөний удирдлагатай холбоотой асуудал, арга хэмжээ, үр дүнгийн нэгдмэл хяналт, хариу арга хэмжээг хариуцан хэрэгжүүлнэ.

Өмнө дурдсанчлан дээрх байгууллагуудын хэрэгжүүлэх шилжилт хөдөлгөөний удирдлагын бүрэн цогц, тохиромжтой байдлыг хангах ажлын гурван тулгуур нь 1) орон нутгийн ажил эрхлэлт, ЭМААБООН, орон нутгийн худалдан авалттай холбоотой ОТ-н стратеги; 2) түншлэгч сумд, Өмнөговийн засаг захиргаатай хамтран хэрэгжүүлэх шилжилт хөдөлгөөний хяналт; 3) нийтийн зориулалттай барилга байгууламжийг түншлэгч сумдын хүн амын өсөлттэй нийцүүлэх тогтвортой хөгжлийн хөтөлбөр, дэд бүтцийн төслүүд (3.2-с харна уу) юм.

Түншлэгч сумдын хүн амын өсөлтийн чиг хандлагыг хянаж, хүлээн зөвшөөрөх боломжгүй шилжилт хөдөлгөөний нөлөөг удирдан зохицуулахад тус болох ОТ-с хянах боломжтой үр дүнгийн үзүүлэлтийг **Хавсралт 4** –д харуулав. Үндсэн үр дүнгийн үзүүлэлт (нийгэм эдийн засаг, хүн амзүйн бодит чиг хандлага), хүссэн зорилго/арга замыг **хавсралт 5**-д оруулав.

Зөвшөөрөгдөх хэмжээний, удирдан зохицуулах боломжтой хүн амын өсөлттэй харьцуулсан нийтийн зориулалттай дэд бүтэц болон үйлчилгээнд нийцсэн дундаас дээд түвшний бүтэц зохион байгуулалт, төлөвлөгөөнд дараах багтана:

- Барилга хот байгуулалтын яам, орон нутгийн захиргаа удирдан боловсруулж, ОТ-с дэмжсэн Ханбогд сумын Ерөнхий төлөвлөгөө. Ерөнхий төлөвлөгөөг 2015 оны 4-р улиралд баталсан.
- Ханбогдод байнга амьдрах ажилтны орон байрны тохиромжтой хувилбарыг тодорхойлох зорилгоор зардал, тогтвортой байдал, ажиллах хүчийг тогтвортой байлгах, аюулгүй ажиллагааны талаас нь судлан үзэх ОТ-н судалгаа. Ажилтанд зориулсан урамшууллын (ээлжийн бүтэц зохион байгуулалт, өдөр тутмын унааны хангалт зэрэг) хэлбэрүүдийг ашиглахын зэрэгцээ нээлттэй зах зээл бий болгох, эзэмших болон түрээслэх хувилбаруудыг дэмжиж байгаа ч дээрх хувилбаруудад үнэлгээ хийж байгаа.
- Ажилтан болон гүйцэтгэгчийн суурьшлыг уян хатан, оновчтой сонгох ОТ-н ажил эрхлэлтийн холимог загвар. 2025 оноос цааш ашиглалтын үйл ажиллагаа болон ОТГУ-н нийт ажилчдын 50%-г Өмнөговьд суурьшуулах зорилгынхоо дагуу ОТ гүйцэтгэх ажил үүрэг, албан тушаалаас нь хамааран үндсэн ажилтан болон гүйцэтгэгчдэд орон нутагт байрлан ажиллах шаардлага тавьж байгаа. Эдгээр хувилбарт Улаанбаатараас ОИОБ, Манлай, Баян-Овоогоос машинаар ирж, машинаар буцах, Ханбогд сумын төвөөс өдөр бүр ажилдаа ирж очдог байх хувилбарууд багтсан. Эдгээр суурин газруудын ажиллах хүчний харьцааг бодит эргэлт, хэрэв шаардлагатай бол ажилтны урамшууллын хөтөлбөрөөр удирдан зохицуулж, ирэх арван жилийн хугацаанд Өмнөговьд суурьших ажилтны тоог нэмэгдүүлсээр 50%-д хүргэнэ.
- ОТ худалдан авах ажиллагааны шаардлагыг жилээс жилд хянан үзэж, Өмнөговьд давуу эрх олгосон гэрээ, нийлүүлэлтийн сүлжээний сонголтуудыг бий болгож, тендерийн шаардлага боловсруулж, гэрээ байгуулах үйл явцыг тодорхойлно. 2016 оны 4 сард Ханбогдод үүссэн хүн амын бүртгэлийн огцом өсөлтийн тохиолдлыг давтахгүйн тулд давуу тал эдлэх эрхтэй байхын тулд заасан байршилд гурван жилээс доошгүй хугацаанд оршин суусаныг нотлох баримт шаардах зэрэг шинэ заалтууд оруулсан.
- ОИОБ ажил амралтын хуваарьтай ажилчдын орон сууцны чанар, тав тухыг шаардлагын хэмжээнд хүргэх зорилгоор ОТ дахь уурхайн талбай дахь кэмпийн байгууламжийг сайжруулж, орон байрны хэрэгцээг хангах. Сайжруулсан кэмп нь ажиллах хүчний орон байрны богиноос урт хугацааны эрэлт хэрэгцээ болон богино хугацааны төлөвлөсөн шилжилт хөдөлгөөнийг удирдан зохицуулах боломж олгоно.

Шилжилт хөдөлгөөнийг удирдах төлөвлөгөөХүчин төгөлдөр болох огноо:
2017.03.31Баримт бичгийн дугаар:
ОТ-10-PLN-0007-МХувилбар:
2.0**8.5. Таамаглал**

8-р хэсэгт дурдсан удирдлагын хяналтын арга хэмжээг боловсруулах чиглэлээр дараах таамаглал хийгдсэнийг оруулав.

- ОТ-н Гүний уурхайн төсөл 2016 оны 6 дугаар сард эхэлсэн бөгөөд 12-14 жил үргэлжилж, ирэх 4-5 жилийн хугацаанд ажлын эрчимжилт өндөр байна.
- Оюу толгой нь ирэх 2-3 жилийн хугацаанд ОИОБ горимоор үргэлжлүүлэн үйл ажиллагаагаа явуулах (Удирдлагын төлөвлөгөөг хянан засварлах дараагийн хугацаа) ба ажиллагсдыг уурхайн талбайд байгуулсан болон шинээр баригдах байранд байрлуулна.
- ОТ одоогийн байдлаар 22 хувь байгаа Өмнөговийн ажиллах хүчний хэмжээг 2025 оноос цааш 50 хувьд хүргэхээр ажиллана.
- ОТ-н зарим ажилтан, гүйцэтгэгчдийг Ханбогдоос ажилд авч, бусад нь хувийн шийдвэрээрээ Ханбогдод шилжин суурьшина.
- ОТ засгийн газрын баталсан Мастер төлөвлөгөөнд нийцүүлсэн чөлөөт зах зээлийг Ханбогд суманд хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллана. Хүн амын өсөлтийн тооцоолсон түвшинд нийцүүлэх, хангах хэмжээний орон сууц, холбогдох дэд бүтэц, үйлчилгээг барьж байгуулах, бий болгох чиглэл удирдамж мастер төлөвлөгөөнд тусгагдсан байна.
- Ханбогд сумын төвийн 10 жилийн хүн амын өсөлт нь ийм хэмжээний суурингийн хувьд удирдан зохицуулж, зөвшөөрөгдөх хэмжээнд буюу жилд 8%-иас бага байна. Ханбогд сумын хүн ам хөдөөд амьдрах нь багасч байгаа байдал хэвээр үргэлжилж, сумын төв болон хөдөөгийн хооронд өдөр тутмын хөдөлгөөний эрчим өндөр байна.
- ОТ-н нийлүүлэгч, гүйцэтгэгчид нь Өмнөговь аймаг, Ханбогд суманд оршин суудаг эсхүл тийш шилжин суурьших ба эдгээр аж ахуй нэгжүүд ОТ-н Өмнөговийн орон нутгийн оролцооны бодлогын хүрээнд давуу эрх эдлэх эрхтэй болно.
- Даланзадгад нь зөвхөн ОТ болон Таван толгойн уурхайнуудаар зогсохгүй, Өмнөговь аймгийн хэмжээнд бусад уурхайг барьж байгуулахад бүс нутгийн үйлчилгээний төв болно. Энэ нь өргөн хүрээний эдийн засгийн боломж, үйл ажиллагааг бий болгож, хүн амын өсөлтийг зохицуулах хүчин чадал багтаамжаараа бусад түншлэгч сумдтай харьцуулбал хавьгүй илүүд тооцогдох Даланзадгад руу чиглэсэн зохицуулах хэмжээний шилжилт хөдөлгөөнийг үүсгэнэ.
- Даланзадгадын хүн амын шилжилт хөдөлгөөний түвшин өнөөгийн төлвөөр ирэх 10 жилийн хугацаанд жилд дунджаар 4.5 хувь буюу Өмнөговийн хэмжээнд дунд зэргийн түвшинд хэвээр байх болно.
- ОТ нь түншлэгч сумдыг хөгжүүлэх, эдийн засгийг тэлэхэд оруулах хувь нэмрээ Хамтын ажиллагааны гэрээгээр (ХАГ) дамжуулан удирдан зохицуулна, үүнд:
 - Нийгмийн суурь үйлчилгээ (эрүүл мэнд, соёл, боловсрол, мэргэжлийн сургалт, ажил эрхлэлт)
 - Орон нутгийн аж ахуйн нэгжүүдийг хөгжүүлэх, бараа, үйлчилгээ, нийтийн зориулалттай дэд бүтцийн байгууламж болон хөрөнгө оруулалтын төслүүд,

9. УДИРДЛАГЫН ХЯНАЛТ

ОТ-н БОННБУ – нд тодорхойлсон болзошгүй нөлөөлөл, боломжууд болон дээр авч үзсэн бодит чиг хандлагуудад үндэслэн 2017 – 2019 онд хяналтын чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх болно. Хяналтын энэхүү арга хэмжээг Орон нутгийн харилцааны багийн шууд дэмжлэгтэйгээр Өмнөговийн Удирдах хороо хянан үзэж, дотооддоо зохицуулалт хийнэ. Үйл ажиллагааны хэлтсүүдтэй холбоотой удирдлагын тусгай хяналт, үйл ажиллагаа, төслүүдийг тухайн хэлтсүүд удирдан зохицуулж, Өмнөговийн Удирдах хороогоор дамжуулан Гүйцэтгэх захирлын багт мэдээлнэ.

Менежементийн гол хяналт нь өргөн хүрээг хамарсан хоёр ангилалд хуваагдана, үүнд;

- Ажилд авах, худалдан авалт хийх нөхцөл, ээлжээр ирж ажиллах ажилтнуудын байр барих зэргээр ажилтан болон гүйцэтгэгчийн оршин суух хэлбэрийг удирдан зохицуулах (гол төлөв зохицуулалттай/төлөвлөсөн шилжилт хөдөлгөөн);
- Орон сууц авах байдлыг нэмэгдүүлэх үүднээс байнгын оршин суух газарт нийтийн зориулалттай дэд бүтцийн байгууламж, үйлчилгээнд хөрөнгө оруулалт хийх, төлөвлөгөөг

Шилжилт хөдөлгөөнийг удирдах төлөвлөгөө

Хүчин төгөлдөр болох огноо:
2017.03.31

Баримт бичгийн дугаар:
ОТ-10-PLN-0007-М

Хувилбар:
2.0

шилжилт хөдөлгөөний улмаас өөрчлөгдөх бодит хүн амд хангалттай хэмжээний үйлчилгээг бий болгох.

Сүүлийн ангилалтай холбоотой менежментийн нарийвчилсан гол хяналтыг **Хавсралт 2**-т, шилжилт хөдөлгөөний хоёр ангиллын хяналтын үүрэг хариуцлагыг **Хавсралт 3** –д тусгасан.

10. ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУВААРЬ

10.1. Хэрэгжүүлэх гол хугацаа

2017 онд удирдлагын төлөвлөгөөг хэрэгжүүлэх гол хугацааг 5-р хүснэгтэд харуулав.

Хүснэгт 5: 2017 онд хэрэгжүүлэх гол хугацаа

Үйл ажиллагаа	Зорилтот хугацаа	Үр дүн
Шилжилт хөдөлгөөний хяналтын хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөөг ӨМУХ, Өмнөговь аймаг болон түншлэгч сумд ХАГХХ-р дамжуулан дотроо зөвшөөрөн батлах	2017 оны 4-р улирал	Төлөвлөгөөг батална
Түншлэгч сумд ХАГХХ-р дамжуулан Орон нутгийн ажил эрхлэлт, сургалтын стратегийг зөвшөөрөн батлах	2017 оны 4-р улирал	Орон нутгийн ажил эрхлэлт, сургалтын стратегийг зөвшөөрнө
Түншлэгч сумд ХАГХХ-р дамжуулан орон нутгийн худалдан авалтын стратегийг зөвшөөрөн батлах.	2017 оны 4-р улирал	Орон нутгийн худалдан авалтын стратегийг зөвшөөрнө
ОТ-ХБ чиглэлийн замын барилгын ажил	2018 оны 4-р улирал	Замыг чанар, зардал, хугацааны шаардлагын дагуу замыг барина
Ханбогдын нийтийн ус хангамжийн төсөл	2017 оны 2-р улирал	Ус хангамжийн дэд бүтцийг барьсан, ашиглалтанд оруулах хугацаа 2017 оны хавар
ОТ кэмп – ажиллах хүчний байршлын стратегийн хүрээнд баригдаж буй шинэ гал тогоо, ажилчдад зориулсан байр	2017 оны 4-р улирал	Шинэ кэмп, гал тогоо барьж, ашиглалтанд оруулсан
Өмнөговьд давуу тал олгох сонголтыг эдлэх эрхтэй болохын тулд 3 жил оршин суусан байх зэргээр ажлын байрны зарыг шинэчилсэн	2017 оны 4-р улирал	Өмнөговьд давуу тал олгох, ажилд авах шинэчилсэн процесс хэрэгжиж эхэлсэн.
Одоогийн байгаа хоёрдогч мэдээллийг баталгаажуулах үүднээс Ханбогдын орон байр/сууц, албан ёсны оршин суух хаяг болон газар худалдан авалтын талаарх мэдээлэл цуглуулах аргыг шинэчилж, сайжруулсан.	2017 оны 4-р улирал	Өмнөх мэдээлэлд дүн шинжилгээ хийж, ӨМУХ болон ХАГХХ-нд хэлэлцүүлж, батлуулахаар хүргүүлсэн.

1.4 Энэхүү менежментийн төлөвлөгөөг хянах, засвар оруулах

Шилжилт хөдөлгөөнийг удирдах төлөвлөгөөХүчин төгөлдөр болох огноо:
2017.03.31Баримт бичгийн дугаар:
ОТ-10-PLN-0007-МХувилбар:
2.0

Энэхүү удирдлагын төлөвлөгөөг 2019 онд ахин хянан үзэх ба өөрчлөгдөж буй нөхцөл байдал буюу ОТ-н үйл ажиллагааны шаардлагыг тусган шинэчилж байна. Энэхүү менежментийн төлөвлөгөөг өөрчлөх, засвар оруулах үүргийг Орон нутгийн харилцааны хэлтсийн Ерөнхий менежер хүлээнэ.

Хэрэв үйл ажиллагааны журамд бодит өөрчлөлт шаардлагатай (ОТ-н Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны менежментийн системд байдаг Өөрчлөлтийн менежментийн журамд (ОТ-11-PRC-0001-Е) тодорхойлсны дагуу) бол энэхүү удирдлагын төлөвлөгөөг “шаардлагын дагуу” өөрчилж болно.

Тус удирдлагын төлөвлөгөөнд оруулах аливаа өөрчлөлт/засварыг ОТ Порталд оруулж, ОТ-н бүх ажилтан удирдлагын төлөвлөгөөний хамгийн сүүлийн хувилбартай танилцах боломж олгоно.

11. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ**11.1. Ерөнхий тойм**

Шилжилт хөдөлгөөнийг хянах үндсэн хоёр арга байдаг.

Нэгдүгээрт, засгийн газрын хоёрдогч мэдээллийг тогтмол цуглуулж, хянах. Үүнд бүртгэлтэй оршин суугчид, ажилгүйдэл, нийгмийн халамжаас хараат байдал, ядуу өрхөд үзүүлэх тусламжид хамрагдагсад, сургуульд элсэн оролт болон төгсөлт, эрүүл мэндийн клиник, эмнэлгийн үйлчилгээ авах, гэмт хэргийн статистик, тээврийн хэрэгслийн бүртгэл зэргийн талаарх аймаг, сумын захиргааны мэдээлэл багтана. Өмнө дурдсанчлан, дээрх мэдээллийг цуглуулдаг төрийн тусгай байгууллага байдаг, дээрх мэдээллийг цуглуулдаг хэдий ч бүртгэл, тайлагналтай холбоотой ашиг сонирхлын зөрчлийн улмаас мэдээлэл тэр бүр баттай, үнэн зөв байж чаддаггүй. Мэдээлэл цуглуулах, ашиглах байдал зарим улс оронтой харьцуулахад илүү сайн ч, үнэн бодит байдлын хувьд зарим талаар хангалтгүй байдаг.

Хоёрдах арга нь шууд олон нийттэй харилцах. ОТ 2003 оноос хойш орон нутагт Орон нутгийн харилцааны ажилтан (ОНХА) ажиллуулж байгаа. Одоогоор Даланзадгад, Манлай, Ханбогд сумдад ОНХА-ууд суурьшин ажиллаж байна (2009-2014 онд Баян-Овоо суманд ОНХА байсан). Тэд орон нутгийн ард иргэд, төрийн албан хаагчид болон ОТ-н хооронд нэн чухал харилцаа холбоо болдог. ОНХА-ууд сумын засаг захиргааны ажилтан (сум, багийн засаг дарга), нийгмийн үйлчилгээ үзүүлэгчид (эмнэлэг, сургууль, цэцэрлэг, цагдаа г.м), орон нутгийн бизнес эрхлэгчид болон малчин өрхүүдтэй нягт хамтран ажилладаг. Ийм арга замаар ОНХА-ууд ОТ-г түншлэгч сумдад явагдаж буй өөрчлөлт, бусад асуудал, санаа зовоосон асуудлын талаар мэдээллээр хангадаг.

ОТ нь дээрх 2 аргаар олж авсан мэдээллийг бие даан, бодитоор баталгаажуулах арга замыг эрэлхийлж, төрийн байгууллага болон ОНХА-ны мэдээллийн үнэн бодит байдлын түвшинг дээшлүүлэхийг зорьж байна. Нэг боломжит арга бол хиймэл дагуулын зургаас сумын төвийн орон сууц/байр болон дэд бүтцийн тооллого явуулах юм. Ийм мэдээлэл нь хоёр ач холбогдолтой байх ба нэгдүгээрт одоогийн байгаа аргын алдааг засах, нөгөө нь ХАГХХ-оор тогтмол бүртгэж, хэлэлцсэнээр албан ёсны тоо бүртгэлд “агентлагийн” үзүүлэх нөлөөг үгүй болгоно.

Дээр дурьдсан хязгаарлалтуудыг харгалзан үзсэний үндсэн дээр хяналт шинжилгээний өөр өөр аргыг ашиглах явцад Рио Тинто, ОТ, ОУСК, ЕСБХ-ны стандартуудад үл нийцсэн болон Ханбогд сумын хүн амыг 10 жилийн хугацаанд жилд ~8 хувиар, Манлай, Баян-Овоо сумдад 0-1 хувиар, Даланзадгадад ~4.5 хувиар нэмэгдүүлнэ гэснээс зөрсөн тохиолдол гарвал шалган баталгаажуулж, шаардлагатай тохиолдолд засч залруулах арга хэмжээ авна.

11.2. Хяналт шинжилгээний гол үйл явц

ОТ-н шилжилт хөдөлгөөний хяналт нь дараах үйл явцаар явагдана:

Шилжилт хөдөлгөөнийг удирдах төлөвлөгөө

Хүчин төгөлдөр болох огноо: 2017.03.31	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0007-М	Хувилбар: 2.0
---	--	------------------

- ОТ-н Орон нутгийн хэлтсийн Ерөнхий менежер улирал тутам ӨМУХ болон ОТ-н Гүйцэтгэх хороонд дараах асуудлаар тайлагнана: (i) Түншлэгч сумдын шилжилт хөдөлгөөний байдал; (ii) Менежементийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явц; (iii) төлөвлөгөөний хэрэгжилтийн дүнд ажиглагдсан нөлөөлөл; (iv) ажиглагдсан нөлөөллийг бууруулахаар авсан хариу арга хэмжээ буюу санал болгож буй үйл ажиллагаа.
- Шилжилт хөдөлгөөний хяналт шинжилгээний талаар хэлэлцэх, төлөвлөгөөнд тусгагдаагүй/төлөвлөгөөнөөс гадуурх нөлөөлөл, чиг хандлагын дагуу авах арга хэмжээний талаар тохиролцох зорилгоор ОТ-н ӨМУХ болон ХАГХХ улирал тутам хуралдана. Шилжилт хөдөлгөөний хяналт шинжилгээний тайлангийн дүгнэлтийг шаардлагатай талуудад хүргүүлнэ.
- Хяналт шинжилгээний хөтөлбөрт тогтмол хэмжигддэг, шаардлагатай зарим тохиолдолд хэмжигддэг үзүүлэлтүүдийн аль алиныг нь багтаасан байна. Тогтмол хэмждэг ердийн мэдээллийн ихэнхийг Орон нутгийн харилцааны баг хоёрдогч эх сурвалжаас цуглуулдаг. Бусад мэдээллийг (төлөвлөөгүй шилжилт хөдөлгөөний нөлөөллийн талаарх ажиглалт г.м) ОТ-н тухайн орон нутаг дахь баг түншлэгч сумдад судалгаа явуулах замаар бүрдүүлнэ.
- Энэхүү төлөвлөгөөний дагуу авч буй нөлөөллийг бууруулах арга хэмжээнд хяналт шинжилгээ хийх үйл явцад орон нутгийн болон бүс нутгийн иргэд, засаг захиргааны байгууллагууд ХАГХХ-оор дамжуулан оролцоно.

ОТ –н Орон нутгийн харилцааны хэлтэс энэхүү Удирдлагын төлөвлөгөөтэй холбоотой бүртгэл/мэдээллийг хөтлөх үүрэгтэй. ОТ-н ӨМУХ болон ХАГХХ хяналт шинжилгээний мэдээлэлтэй танилцаж, мэдээлэл цуглуулах арга, үүрэг хариуцлага, зорилго, хариу арга хэмжээний хязгаар/босгын талаар хэлэлцэж, ЗГ, ОТ, бусад хөрөнгө оруулагчид болон бүс нутаг дахь уул уурхайн компаниудтай шилжилт хөдөлгөөний менежментийн зохицуулалтыг хийхэд тусална. Гол ажлын бүтээмж, үр дүнгийн үзүүлэлт, хяналт шинжилгээний арга хэмжээг **Хавсралт 4, 5-д** харуулав.

Рио Тинтогийн ЭМААБООН-н бизнесийн үйл ажиллагааны нийцлийн/тохирлын аудитаар ОТ Рио Тинтогийн шаардлагад нийцэж байгаа эсэхийг тогтмол (ажлын гүйцэтгэл, эрсдэлд үндэслэн жил тутам эсхүл хоёр жил тутам) хянана. Нөхцөл байдлын дагуу ОТ-н үйл ажиллагааны хугацаанд шилжилт хөдөлгөөний удирдлагад бусад хөндлөнгийн үнэлгээ хийгдэнэ.

11.3. Оролцогч талууд

Шилжилт хөдөлгөөний хяналт шинжилгээ, удирдлагад зөвлөх, оролцох бусад гол оролцогч талуудыг Хүснэгт 6-д харуулав. Удирдлагын төлөвлөгөөний талаар ОТ-н дотоод оролцогч талуудтай хамтран ажиллах эхний процесс нь ХАГХХ байх ба Өмнөговийн гадны оролцогч талуудтай уулзах анхан шатны хурал уулзалтыг ХДС, ХАГХХ болон төрөл бүрийн ажлын хэсгүүдээр дамжуулан явуулна.

Хүснэгт 6: ОТ-н тодорхойлсон гол оролцогч талууд

Дотоод оролцогч талууд	Гадаад оролцогч талууд
<ul style="list-style-type: none"> • Үйл ажиллагаа, дэд бүтцийн үйлчилгээ, гүний уурхай • Хүний нөөц • Хангамж • Гадаад харилцаа • Байгаль орчин • Олон нийтийн харилцаа, хэвлэл 	<ul style="list-style-type: none"> • Түншлэгч сумдын иргэд • ӨГУХ > ӨМТХ • ХАГХХ болон ХДС • Засгийн газрын холбогдох яамд, агентлагууд • <i>Аймгийн</i> Засаг даргын тамгын газар, түүний агентлагууд • <i>Сумын</i> Засаг даргын тамгын газар, захиргааны

Шилжилт хөдөлгөөнийг удирдах төлөвлөгөөХүчин төгөлдөр болох огноо:
2017.03.31Баримт бичгийн дугаар:
ОТ-10-PLN-0007-МХувилбар:
2.0

Дотоод оролцогч талууд	Гадаад оролцогч талууд
мэдээлэл <ul style="list-style-type: none">ОТ Өмнөговийн Удирдах хорооОТ –н ажилтнуудНийлүүлэгч, гүйцэтгэгчид, тэдний ажиллагсадОТ Ахлах удирдлагын баг	ажилтнууд <ul style="list-style-type: none">Нийгмийн үйлчилгээ үзүүлэгчидБоломж хайсан хүн амын шилжилт хөдөлгөөн – албан ёсны эрхэлсэн ажилгүй хүмүүс Ханбогд суманд ирж суурьшихУурхайн нөлөөллийн сумдад байрлах хөрөнгө оруулагчид ба бүтээн байгуулагчид/барилгын ажил эрхлэгчидОрон нутаг, бүс нутгийн иргэний нийгмийн бүлгүүд

12. СУРГАЛТ

Танилцуулах сургалтын (ерөнхий ойлголт өгөх) хүрээнд бүх шаардлагатай болон тухайн ажлын байранд зориулсан тусгай сургалтанд хамруулна. Бүх ажилтан (ажилтнууд болон гэрээт ажиллагсад) танилцах ерөнхий хөтөлбөрийн хүрээнд соёл заншлын ялгааг хүндэтгэх болон хүний эрхийн сургалтанд хамрагдсан байх шаардлагатай. Үүний дээр, нутгийн иргэдийн дунд биеэ хэрхэн авч явах талаар компаниас тавигдах шаардлагыг мөрдөж, ёс зүйн хэм хэмжээг сахих шаардлагатай.

Хүн амын шилжилт хөдөлгөөний зохицуулалт, хяналт шинжилгээ, мэдээлэл цуглуулах талаар тусгай сургалтуудад энэхүү удирдлагын төлөвлөгөөнд орсон үйл ажиллагаанд оролцох буюу хянах ОТ-н ОНХА-ууд, бусад ажиллагсад, ялангуяа Хангамж, Хүний нөөц, Байгаль орчин, Төсөл хариуцсан болон, Засгийн газартай харилцах хэлтсийн удирдлагуудыг хамруулна. Шилжилт хөдөлгөөний удирдлагын үйл ажиллагаанд оролцох гол ажилтныг шаардлагын дагуу мэргэжлийн нэмэлт сургалтанд хамруулна.

13. АУДИТ БА ТАЙЛАГНАЛ**13.1. Дотоод аудит**

Энэхүү төлөвлөгөөний гүйцэтгэлийг дотоод хяналт шалгалт болон аудитын шалгалтанд жил бүр оруулна. Хяналт шалгалтын явцад илэрсэн аливаа осол зөрчлийг Байгаль орчин, нийгмийн менежементийн төлөвлөгөөний баримт бичгийн 16-р элементийн дагуу мэдээлнэ. Гүйцэтгэлийг/тохирлыг Байгаль орчин, нийгмийн менежементийн төлөвлөгөөний баримт бичгийн 16-р элементийн дагуу жилийн дотоод аудитаар хянан шалгана.

13.2. Хөндлөнгийн/гадаад аудит

Энэхүү төлөвлөгөөний гүйцэтгэлийг Рио Тинто компаниас үнэлгээ, аудит хийн тогтмол шалгах ба мөн төслийн зээлдүүлэгчид шалгана.

13.3. Тайлагнал

Энэхүү төлөвлөгөөнд хийгдэх аудитын шалгалтын үр дүнг ОТ-н ӨГБХЗ, Гүйцэтгэх хороо болон ХАГХХ-нд ирүүлнэ.

Шилжилт хөдөлгөөнийг удирдах төлөвлөгөө

Хүчин төгөлдөр болох огноо:
2017.03.31

Баримт бичгийн дугаар:
ОТ-10-PLN-0007-М

Хувилбар:
2.0

14. БАРИМТ БИЧГИЙН МЭДЭЭЛЭЛ

Файлын нэр	ОТ-10-PLN-0007-Е-Шилжилт хөдөлгөөнийг удирдах төлөвлөгөө
Тодорхойлолт	Ашиглалтын шатны Шилжилт хөдөлгөөнийг удирдах төлөвлөгөө
Эх зохиогч	ОНХХ-ийн Ерөнхий менежер Шуркагийн Байгалмаа
Боловсруулсан огноо	2013.09.01
Баталсан	ОНХХ-ийн Ерөнхий менежер Шуркагийн Байгалмаа
Баталсан огноо	2013.09.01
Өөрчлөлтийн бүртгэлийн дугаар	#

Эрсдэлийн зэрэглэл	Үнэлгээ хийсэн огноо	Эрсдэлийн үнэлгээ хийсэн	Дахин хянах хуваарь	Дараагийн хянах огноо
Дунд	2013.09.01	ОНХХ-ийн Ерөнхий менежер Шуркагийн Байгалмаа	2 жилд нэг удаа	2017.08.01

Хувилбар	Хянасан огноо	Зохиогч (ид)	Баталсан	Хянасан тэмдэглэл
1.0	2013.09.01	ОНХХ-ийн Ерөнхий менежер Шуркагийн Байгалмаа	ОТ Гүйцэтгэх хороо	Баталсан хувилбар,
1.1	2013.11.23	Л.Мөнхцацрал	ОТ Гүйцэтгэх хороо	Баримт бичгийн дугаарыг зассан мөн баримт бичгийн удирдлагын хэсгийг дуусгасан.
1.2	2016.06.20	Г.Сугар Д.Махони	ОНХХ-ийн Ерөнхий менежер Шуркагийн Байгалмаа	МОС# НОС # Тогтмол хянаснаар Хамтын ажиллагааны гэрээ болон шинээр цуглуулсан мэдээлийг оруулж шинэчлэв
2.0	2017.03.31	Г.Сугар Ж.Боукок	ОНХХ-ийн Ерөнхий менежер Шуркагийн Байгалмаа	Амжилттай гүйцэтгэсэн гадаргын үйл ажиллагаа, ОТ-н Гүний уурхайн төсөл, хүчин төгөлдөр Шилжилт хөдөлгөөнийг удирдах төлөвлөгөөний эхний гурван жилийн мэдээллийг харгалзан үзэж дахин боловсруулав.

Шилжилт хөдөлгөөнийг удирдах төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2017.03.31	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0007-М	Хувилбар: 2.0

ОТ Шилжилт хөдөлгөөнийг удирдах төлөвлөгөөний хавсралтууд

Шилжилт хөдөлгөөнийг удирдах төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2017.03.31	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0007-М	Хувилбар: 2.0

ХАВСРАЛТ 1: ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ СӨРӨГ НӨЛӨӨГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ШУУД БОЛОН ШУУД БУСААР ОРУУЛСАН ТОМООХОН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХУРААНГУЙ

Жил	Сум	ОТ –н оруулсан хувь нэмэр
